

АМЕП2 - МОНВАЛ КОД

IMVAL Загвар болон Олон улсын Кодуудын харьцуулалт

Төсөл 1

2019 оны 10 сарын 20 ны өдөр

ТЭМДЭГЛЭЛ

Ерөнхий

- 1) Энэхүү баримт бичгийн Удирдамжийн заалтууд нь холбогдох кодын заалттай уялдуулан өөрчилж байрлуулснаас бусад тохиолдолд, IMVAL Загварын дарааллыг дагана. Гарчиг бүр нь IMVAL Загварын заалт, дараа нь CIMVAL, SAMVAL, SME, VALMIN Кодын гэсэн заалтуудаар (дарааллан) харуулна.
- 2) Доогуур зурсан тайлбар нь тухайн анхдагч баримт бичгийн заалтуудын гарчиг эсвэл дэд гарчгийг заана.
- 3) CIMVAL кодыг 2003 онд анх боловсруулсан. CIMVAL хороо одоогоор шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж байна. Кодын хугацаанаас шалтгаалан, саяхан боловсруулсан CIMVAL кодын шинэчилсэн найруулгын төслийг (CIMVAL Төсөл) энэхүү баримт бичигт харьцуулах зорилгоор ашигласан болно.
- 4) CIMVAL Төсөлд "Үнэлгээний товч тайлан" гэсэн ойлголтыг танилцуулсан бөгөөд энэ нь IMVAL Загвар болон бусад харьцуулсан кодоод байхгүй. Энэ нь эцсийн байдлаар CIMVAL кодонд батлагдах нь эргэлзээтэй тул MONVAL кодтой холбоотой эсэх нь мөн эргэлзээтэй.
- 5) "[" Ба "]" дөрвөлжин хаалтууд нь гадаадын кодын шууд ишлэл биш гэсэн тэмдэглэгээнд ашигласан.

Удирдамж

- 1) Энэ баримт бичигт, гадаадын кодын "Удирдамж" хэсэг нь налуу байна.
- 2) IMVAL Загвар, SME Үнэлгээний Стандартын бүх "Удирдамжууд" нь Кодын заалтын дагуу тусдаа хэсэгт байна. VALMIN кодын хувьд, удирдамж нь кодын заалтаас өөрөөр байна.

ЗАРЧИМ

Үндсэн зарчим

IMVAL: Үнэлгээг хийхэд үндсэн гурван зарчмыг баримтлана, үнэлгээний тайлан нь мэргэжлийн түвшинд, материаллаг, ил тод байна. Мөн, эдгээр үндсэн зарчмаас гадна объектив, хараат бус, үндэслэлтэй байх зарчмууд нь үндэсний код, стандартуудын дагуу хэрэгжиж болно.

CIMVAL DRAFT: Үнэлгээг хийх үндсэн зургаан зарчим байх бөгөөд, үнэлгээний тайлан нь мэргэжлийн, материаллаг, үндэслэлтэй, ил тод, хараат бус, объектив байна.

SAMVAL: Энэ код нь үндсэн зарчимд суурилсан код, тодорхой суурь зарчмуудыг баримтлах ёстой бөгөөд, үүнд Итгэмжлэгдсэн Үнэлгээчдийн (ИҮ) мэргэжлийн үнэлгээг үндэслэх, бусдын үнэлгээг дүгнэх чадамжтай байна. Энэ код нь Итгэмжлэгдсэн Үнэлгээчдийн дагаж мөрдөх суурь зарчимуудаар хоорондоо ялгаатай, илүү ёс зүйд суурилсан удирдамж зарчмууд (дараагийн хэсэгт тайлбарлана) байна. Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь үнэлгээг хийхдээ материаллаг, ил тод, мэргэжлийн, үндэслэлтэй байдлыг хангана.

SME: Үнэлгээг хийхдээ үндсэн дөрвөн зарчмыг баримтлах ёстой бөгөөд үнэлгээний тайлан нь мэргэжлийн түвшинд, материаллаг, объектив, ил тод байна. Мөн, эдгээр үндсэн зарчмаас гадна, хараат бус, үндэслэлтэй байх зарчмууд нь үндэсний код, стандартуудын дагуу Ашигт Малтмалын Үнэлгээнд хэрэгжүүлж мөрдөнө.

SME-ийн стандартын хараат бус байх зарчмыг байнга шаарддаг. Үндэслэлтэй байх зарчмыг дурдаагүй.

VALMIN: Мэргэжлийн, Материаллаг, Ил тод байх үндсэн зарчмыг баримтлана. Мөн эдгээр зарчмуудын нэмэлт шаардлагууд нь Үндэслэлтэй, Хараат бус байна.

Мэргэжлийн үр чадвар

IMVAL: Үнэлгээчин нь үйлчлүүлэгч байгууллага, үнэлгээний тайлан хийлгэж байгаа хамаарал бүхий хуулийн этгээдэд үнэлгээний тайлан хийх эсвэл бэлтгэх хангалттай мэргэжлийн үр чадвар байгаа эсэхийг харуулах ёстой. Үнэлгээчин нь үнэлгээ хийх явцдаа бусад мэргэжлийн үнэлгээчидтэй хамтрах, хангалттай мэргэжлийн үр чадвартай гэдгээ харуулах ёстой. Бусдаар, үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийн хувьд, хөрөнгийн худалдаа, зах зээл, үнэлгээний зорилгод нийцүүлэн өөрсдийн мэргэжлийн үр чадвараа үнэлнэ. (IVS Мэргэжлийн үр чадвар, Заалт 50-аас харна уу)

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ нь өргөн хүрээний мэдлэг, мэргэжлийн үр чадварыг шаардана. Тухайн үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгийн шинж чанар, үнэ цэнийн, тухайн үеийн холбогдох техникийн тайлангийн боломжтой байдлаас хамааран геологийн шинжлэх ухаан, уул уурхай эсвэл газрын тосны инженер, металлург, усны зөвшөөрөл, байгал орчны үнэлгээ, нийгмийн хүчин зүйлүүд, орон нутгийн геополитик, микро болон макро эдийн засаг, санхүү, татвар болон засгийн газрын хураамжууд, хөрөнгө, ашигт малтмал болон бусад хууль тогтоомжууд, том оврын тээвэрлэлт болон зах зээлийн талаархи өргөн цар хүрээний ойлголтуудыг шаардана.

Тиймээс, ихэнх тохиолдолд, Үнэлгээчин нь Үнэлгээний тайлан хийхдээ, Ашигт малтмалын Хөрөнгийн Үнэлгээнд ашигласан техникийн өгөгдөл болон мэдээлэллийг боловсруулах, шалгах явцад мэргэжлийн үр чадвар бүхий Зөвлөхийг байлгах нь зүйтэй.

Зарим харьяа газруудад тухайн холбогдох чиглэлээр хамгийн доод ажилласан хугацаа, туршлагыг шаардаж болно. CRIRSCO загвараас харвал, холбогдох тухайн чиглэлээр доод тал нь 5 жил ажилласан туршлагатай байхыг шаарддаг байна. IVS Хамрах хүрээ 4,5. Үнэлгээчнийг зарим газруудад үнэ тогтоогч/тодорхойлогч эсвэл үнэлэгч гэж нэрлэдэг.

CIMVAL DRAFT: Мэргэшсэн Үнэлгээчнийг үнэлэх, сонгох нь тухайн үйлчлүүлэгчийн үндсэн хариуцлага ба, Мэргэшсэн Үнэлгээчин нь үйлчлүүлэгч, үнэлгээний тайлан хийлгэж байгаа хамаарал бүхий хуулийн этгээдэд үнэлгээний тайлан хийх эсвэл бэлтгэх хангалттай мэргэжлийн ур чадвартай эсэхээ нотлох ёстой. Мэргэшсэн Үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ бусад мэргэжлийн үнэлгээчидтэй хамтрах, хангалттай мэргэжлийн ур чадвартай эсэхээ харуулах ёстой. Бусдаар, Мэргэшсэн Үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийн хувьд, хөрөнгийн худалдаа, зах зээл, үнэлгээний зорилгод нийцүүлэн өөрсдийн мэргэжлийн ур чадвараа үнэлнэ. (IVS Мэргэжлийн ур чадвар, Заалт 50-аас харна уу)

Хэрвээ Мэргэшсэн Үнэлгээчин нь үнэлгээний бүх чиглэлд ур чадварын хувьд хангалтгүй бол, тухайн шаардлагатай асуудлуудыг шийдэх, тухайн чиглэлээр мэргэшсэн ур чадвар бүхий нэг болон түүнээс дээш Мэргэшсэн мэргэжилтнүүд болон бусад Экспертүүдээс туслалцаа авах ёстой. Жишээ нь: Үнэлгээ хийхдээ Мэргэшсэн үнэлгээчин нь техникийн тайлан бэлтгэсэн Мэргэшсэн мэргэжилтнээс хамаарч болно. Материалын тусламж, бусад Экспертүүдтэй хамаарлын байдлаа Үнэлгээний тайланд тусган мэдээлэх ёстой.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ нь өргөн цар хүрээний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг шаардана. Тухайн үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгийн шинж чанар, үнэ цэнийн суурь, тухайн үеийн холбогдох техникийн тайлангийн боломжит байдлаас хамааран олон мэргэжлийн өргөн цар хүрээний ойлголтуудыг шаардана. Тиймээс, ихэнх тохиолдолд, Мэргэшсэн Үнэлгээчин нь Үнэлгээний тайлан бэлтгэх, Ашигт малтмалын Хөрөнгийн Үнэлгээний техникийн өгөгдөл болон мэдээллийг боловсруулах, шалгах явцад мэргэжлийн ур чадвар бүхий Мэргэшсэн Мэргэжилтэн, Зөвлөхийг байлгах нь зүйтэй.

Үйлчлүүлэгчтэй хамаарал бүхий Эксперт болон Экспертийн тайлан, эсвэл техникийн мэдээллийг Үнэлгээний тайланд бүрэн хэмжээгээр тусгаж мэдээлнэ.

SAMVAL: Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь ашигт малтмалын хөрөнгийг үнэлэх шаардлагатай мэргэшил, чадвар, хангалттай холбогдох туршлагыг эзэмшсэн байна. Үнэлгээчнийг Итгэмжлэгдсэн үнэлгээчин гэх бөгөөд үнэлгээг хийхдээ мэргэшсэн, бусад үнэлгээчдийн үнэлгээг дүгнэх, өөрийн үзэл бодлоо тодорхой илэрхийлэх чадвараа нотлоно. Итгэмжлэгдсэн Үнэлгээчин нь ECSA, SACNASP, SAGC, эсвэл SAIMM, GSSA, SAICA-ын гишүүн эсвэл Хүлээн зөвшөөрөгдсөн Мэргэжлийн байгууллага, эсвэл энэ зорилгоор JSE -ын нэрийн өмнөөс SSC – аар хүлээн зөвшөөрсөн, Ёс зүйн дүрэм, Сахилгын кодуудыг баримталдаг бусад мэргэжлийн байгууллагууд, Хавсралт В-д заасан чадваруудыг хангаж, бүртгэгдсэн байна. Хүлээн зөвшөөрөгдсөн Мэргэжлийн Байгууллагын (RPOs) жагсаалтыг SAMCODE-ын вэбсайт дээр SSC байгууллага байршуулах бөгөөд, энэ нь байнга шинэчлэгдэнэ.

SME: [2 догол мөрийн хамгийн сүүлийн өгүүлбэрүүдийг хассан (IVS Хамрах хүрээг лавлана уу), бусад тохиолдолд IMVAL Загвартай адил]

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ нь өргөн цар хүрээний мэдлэг, мэргэжлийн ур чадварыг шаардана. Тухайн үнэлгээ хийх болон худалдааны зорилгоор үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгийн шинж чанар, үнэ цэнийн суурь, тухайн үеийн холбогдох техникийн тайлангийн боломжит байдлаас хамааран геологийн шинжлэх ухаан, уул уурхай эсвэл газрын тосны инженер, металлург, усны зөвшөөрөл, байгал орчны үнэлгээ, нийгмийн хүчин зүйлүүд, орон нутгийн геополитик, микро болон макро эдийн

засаг, санхүү, татвар болон засгийн газрын хураамжууд, хөрөнгө, ашигт малтмал болон бусад хууль тогтоомжууд, том оврын тээвэрлэлт, зах зээлийн гэх мэт олон мэргэжлийн өргөн цар хүрээний ойлголтуудыг шаардана.

Тиймээс, ихэнх тохиолдолд, Үнэлгээчин нь Үнэлгээний тайлан хийхдээ, Ашигт малтмалын Хөрөнгийн Үнэлгээнд ашигласан техникийн өгөгдөл болон мэдээллийг боловсруулах, дүгнэх мэргэжлийн ур чадвар бүхий Экспертийг байлгах нь зүйтэй. IVS Хамрах хүрээ, §5-ыг харна уу. Зарим газруудад тухайн холбогдох чиглэлээр хамгийн доод ажилласан хугацаа, туршлагыг шаардаж болно. 2014 SME Guide нь Хамрах хүрээнд тухайн холбогдох чиглэлээр доод тал нь 5 жил ажилласан туршлагатай байхыг шаарддаг.

VALMIN: Мэргэших эсвэл мэргэшсэн байдал нь Олон нийтийн тайланг Мэргэжлийн ёс зүйн кодын дагуу туршлагатай, тохирох ур чадвартай этгээдийн хариуцлагад суурилсан ажлыг шаарддаг. Мэргэжилтэн (Practitioner) нь Олон нийтийн тайлан боловсруулахад оролцох ёстой, мөн бусад холбогдох мэргэжилтнүүдээс тусламж хэрэгтэй байж болно. Бүх мэргэжилтнүүд нь холбогдох техникийн болон худалдааны чиглэлд мэргэшсэн ур чадвартай байх ёстой.

Олон нийтийн тайлангийн шинж чанраас хамааран, геологийн шинжлэх ухаан, инженер, металлурги, байгаль орчны үнэлгээ, геополитик, санхүү, татвар, хууль, үнэлгээ, худалдаа зэрэг хувиргагч хүчин зүйлээс хамаарсан бүх мэргэшлүүд шаардлагатай байж болно. Мэргэжилтнүүд нь үйлчлүүлэгч буюу олон нийтийн тайланг хүлээн авах байгууллагад олон нийтийн тайлан бэлтгэх эсвэл оролцох хангалттай чадвар, мэргэшсэн байдлаа харуулах чадамжтай байх ёстой.

Материаллаг байдал

IMVAL: Үнэлгээ нь бүх мэдээллийг харгалзан үзэх ёстой. Үнэлгээний тайланд бүх мэдээллүүдийг хангалттай багтаах ёстой. Материаллаг байх үндсэн зарчим нь тухайн мэдээлэл нь үнэлгээтэй холбоотой эсэхийг тодорхойлох юм. Материаллаг байдал нь тухайн зүйлийн шинж чанарын үнэлгээнд хамаарах ба, үнэлгээний тоо хэмжээнд нөлөөлнө. Үнэлгээчин нь үнэлгээний тайлан хийх явцдаа параметрууд, эрсдлүүд, хязгаарлалтууд, бусад холбоотой нөлөөллийн материаллаг байдлыг илэрхийлэх бүх таамаглалыг тодорхой харуулах ёстой. IVS 103 Тайлан, Заалт 30 Үнэлгээний тайлан хэсгээс харна уу.

Материаллаг байдлын тодорхойлолт эсвэл холбогдох үнэлгээ нь чанрын болон тооны гэсэн хоёр хүчин зүйлээс хамаарна.

Тухайн зүйлийн онцлог шинж чанар, жишээ нь улс төрийн эрсдэл зэргээс хамаараад параметр нь чанрын хувьд материаллаг байж байна. Үнэлгээчин нь бүх материаллаг мэдээллүүдийг авч үзэн тодорхойлсон байна.

Мэдээллийн материаллаг эсэхийг тодорхойлох ерөнхий зарчим нь мэдээллийг орхигдуулах, эсвэл худал ташаа мэдээлснээр Үнэлгээний тайлангийн зорилтот хэрэглэгчийн шийдвэрт хэр их нөлөөлөхийг харгалзан үзнэ. Мэдээллийн Материаллаг байдлыг тодорхойлоход Мэргэжлийн дүгнэлт шаардлагатай байж болно. Материаллаг байдлыг тодорхойлоход хоёр төстийг хэрэглэдэг – чанрын тест (энэ нь тухайн зүйлийн шинж чанар, мэдээлэл нь хэрэглэгчийн шийдвэрт нөлөөллөх эсэх), тоон тест нь хувь хэмжээгээр илэрхийлэгдэнэ.

Хэрвээ үнэлгээчин нь хангалттай үнэн зөв, найдвартай өгөгдөл авах боломжгүйг мэдсэн тохиолдолд үүний талаар Үнэлгээний тайланд мэдээлнэ. Үнэлгээчин нь боломжит өгөгдлийн хэмжээ, чанраас хамааран Үнэ цэнийн талаар байр сууриа мэдээлэхгүй байж болно. Үнэлгээчин нь нэг юмуу түүнээс дээш таамаглалууд, эсвэл Тусгай таамаглал хийсэн тохиолдолд, ил тод мэдээлэх ёстой.

CIMVAL DRAFT: Үнэлгээнд бүх мэдээллийг авч үзэх ёстой. Бүх мэдээллийг Үнэлгээний тайланд хангалттай багтааж тайлбарлах ёстой. Материаллаг байх үндсэн зарчим нь тухайн мэдээлэл нь үнэлгээтэй холбоотой эсэхийг тодорхойлох юм. Материаллаг байдал нь тухайн зүйлийн шинж чанарын үнэлгээнд хамаарах ба, үнэлгээний тоо хэмжээнд нөлөөлнө.

Мэргэшсэн Үнэлгээчин нь үнэлгээний тайлангийн параметрууд, эрсдлүүд, хязгаарлалтууд, бусад холбоотой нөлөөлж болох бүх материаллаг таамаглалыг тодорхой мэдээлэх ёстой.

Материаллаг байдлын тодорхойлолт эсвэл үнэлгээнд холбоотой эсэх нь чанрын болон тооны гэсэн хоёр хүчин зүйлээс хамаарна. Мэдээллийн материаллаг эсэхийг тодорхойлох ерөнхий зарчим нь мэдээллийг орхигдуулах, эсвэл худал ташаа мэдээлснээр Үнэлгээний тайлангийн зорилтот хэрэглэгчийн шийдвэрт хэрхэн нөлөөлөхийг авч үзнэ.

Хэрвээ Мэргэшсэн Үнэлгээчин нь хангалттай үнэн зөв, найдвартай өгөгдөл авах боломжгүйг мэдсэн тохиолдолд, Үнэлгээний тайланд тухайн хязгаарлалтын талаар мэдээлэх. Мэргэшсэн Үнэлгээчин нь боломжит өгөгдлийн хэмжээ, чанраас хамааран Үнэ цэнийн талаар байр сууриа мэдээлэхгүй байж болно. Мэргэшсэн Үнэлгээчин нь нэг буюу түүнээс дээш таамаглалууд, эсвэл Тусгай таамаглал хийсэн тохиолдолд, ил тод мэдээлэх ёстой.

SAMVAL: Олон нийтийн тайлан нь Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд үндэслэн, тэнцвэртэй дүгнэлт хийхийн тулд хөрөнгө оруулагчид, мэргэжилтнүүд, зөвлөхүүд ба / эсвэл хуулийн этгээдэд шаардагдах, олж мэдэхийг хүссэн бүхий л холбогдох мэдээллийг багтаасан байна.

SME: [2 догол мөрийн 2 дахь өгүүлбэрийг хассан (IVS -аас харна уу), бусад тохиолдолд IMVAL Загвартай адил]

[SME Удирдамж нь IMVAL Загвартай адил]

VALMIN: Материаллаг болон Материаллаг байхад нийцүүлэн Олон нийтийн тайлан нь Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд үндэслэж, тэнцвэртэй дүгнэлт хийхийн тулд хөрөнгө оруулагчид, мэргэжилтнүүд, зөвлөхүүд ба / эсвэл хуулийн этгээдэд шаардагдах, олж мэдэхийг хүссэн бүх холбогдох мэдээллийг багтаасан байна.

Олон нийтийн тайланд бүх таамаглалуудыг (дараахи бүлгүүдэд тайлбарласанаар) (i) Материаллаг, техникийн болон худалдааны параметрууд, (ii) таамаглалтай холбоотой эрсдлүүд; (iii) Ашигласан Үнэлгээний хандлагууд болон аргуудыг багтаан зохих лавлагаа, олонд ил гаргаагүй нууц мэдээллийг тодорхой мэдээлэх ёстой. VALMIN кодоос гадуурхи Үнэлгээнд Материаллаг нөлөө үзүүлэхгүй байх ёстой ба, үүнийг олон нийтийн тайланд мэдээлэн, дүгнэх ёстой.

Хангалттай үнэн зөв, баталгаатай өгөгдөл авах боломжгүй тохиолдолд, Олон нийтийн тайланд мэдээлэх.

Австралийн Хуулийн зохицуулалтын шаардлагын талаархи нэмэлт мэдээллийг ASIC-ын Зохицуулалтын удирдамж RG 111-аас авч болно. Материаллаг байдлын тодорхойлолт эсвэл үнэлгээтэй холбоотой эсэх нь чанрын болон тооны гэсэн хоёр хүчин зүйлээс хамаарна. Параметр нь тухайн зүйлийн онцлог шинж чанраас хамаараад чанрын хувьд материаллаг байж болно (жишээ нь: улс төрийн эрсдэл). Мэргэжилтэн нь бүх мэдээллийг авч үзсэн эсэхийг баталгаажуулна.

Мэдээллийн материаллаг эсэхийг тодорхойлох ерөнхий зарчим нь “Хэрвээ мэдээллийг орхигдуулан, эсвэл худал ташаа мэдээлснээр Олон нийтийн тайланд үндэслэсэн хэрэглэгчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөл”-ийг хэлнэ [Олон улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Хороо, 1989].

Материаллаг байдлыг хувь, вариациар тодорхойлох удирдамжыг Австралийн Нягтлан бодох бүртгэл, Олон улсын Санхүүгийн Тайлангийн Стандартаас үзэж болно.

Нийт дүн нь 10 хувьтай тэнцүү, эсвэл бага тохиолдолд, хэрвээ үүний эсрэг баримт, нотолгоо байхгүй бол Материаллаг гэж үзнэ. Нийт дүн нь 5 хувьтай тэнцүү, эсвэл бага тохиолдолд, хэрвээ үүний эсрэг баримт, нотолгоо байхгүй бол шаардана Материаллаг гэж үзэхгүй.

Тухайн зүйлийг Материаллаг эсвэл, үгүй эсэхийг тодорхойлохын тулд хоёр тестээр туршина: (i) Тоо хэмжээн тест (хувь вариациар); энэ нь “мэдэх шаардлагатай”, “мэдэхэд таатай байна” гэсэн мэдээллийг хооронд нь тодорхойлох, холбогдох мэдээллийг тодорхойлох мэргэжлийн түвшинд дүгнэлтийг шаардана (ii) чанрын тест нь тухайн зүйлийн шинж чанар, мэдээлэл нь хөрөнгө оруулагчийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөл.

Чанрын хүчин зүйлийн талаархи удирдамжыг ASX-ын Үнэт цаас Бүртгэлийн Заавар, Тэмдэглэл 31 -ээс олж үзнэ үү.

Ил тод байдал

IMVAL: Үнэлгээний үйл явц, Үнэлгээний тайлан нь ил тод байх бөгөөд, эдгээр нь тодорхой, зөв илэрхийлсэн, ойлгомжтой байна.

Ил тод байх зарчим нь мэдээллийг бага эсвэл тодорхой бус хэлбэрээр мэдээлэхгүй байх, үүнээс шалтгаалаад тухайн мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч буруу үр дүн, дүгнэлт гаргах боломжтой байдаг. Материаллаг асуудлуудад илүү нарийн нягт үндэслэлтэй, тайлбар дүгнэлтийг хийж мэдээлнэ.

Ил тод байдал нь Үнэлгээний тайлан хийхэд объектив байдлыг дэмжих, субъектив байдлыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ. Ил тод үнэлгээний тайлан нь товч тодорхой бичсэн, гаргацтай ойлгомжтой хүснэгтүүд, графикууд, газрын зургууд, фото зургуудыг хавсаргасан байна. Хэрвээ товч тодорхой байх боломжгүй тохиолдолд, Материаллаг мэдээллийг нилээд ойлгомжтойгоор илэрхийлнэ.

Үнэлгээний дүгнэлт нь Үнэлгээчний тайланд тусгасан гол таамаглалын харилцан нөлөөллөөс хамаарна. Чанар нь Үнэлгээний тайланд суурь болгон хэрэглэсэн өгөгдөл, мэдээлэл, дүн шинжилгээ, танилцуулгад хамаарна.

Чанрын хүчин зүйлсүүдийг Ашигт малтмалын нөөц, баялгын үнэлгээ, олборлолт, ашиглалт, баяжуулалт, маркетинг, Үнэлгээний хандлагууд, тохирох арга аргачлалуудад хэрэглэн, Үнэлгээний тайланд тодорхой мэдээлнэ.

CIMVAL DRAFT: Үнэлгээний үйл явц, Үнэлгээний тайлан нь ил тод байна, Материаллаг таамаглал, дүгнэлтүүд нь уншигчдад тодорхой, зөв илэрхийлсэн, ойлгомжтой байна. Үнэлгээний дүгнэлтэд нөлөөлөх үнэлгээний бүх материаллаг таамаглал, аливаа хязгаарлалтыг үнэлгээний тайланд мэдээлэх ёстой.

Ил тод байх зарчим нь мэдээллийг бага эсвэл тодорхой бус хэлбэрээр мэдээлэхгүй, үүнээс шалтгаалан тухайн мэдээллийг хүлээн авсан хэрэглэгч буруу үр дүн, дүгнэлт гаргах боломжтой байдаг. Материаллаг асуудалд илүү нарийн нягт үндэслэлтэй, тайлбар дүгнэлт хийж мэдээлнэ.

Ил тод байдал нь Үнэлгээний тайлан хийхэд объектив байдлыг дэмжих, субъектив байдлыг бууруулахад дэмжлэг үзүүлнэ.

Ил тод үнэлгээний тайлан нь товч тодорхой бичсэн, гаргацтай, ойлгомжтой хүснэгтүүд, графикууд, газрын зургууд, фото зургуудыг хавсаргасан байна. Мөн, Үнэлгээний хандлагууд, тохирох арга аргачлалууд, тэдгээрийн хэрэглээг Үнэлгээний тайланд тодорхой мэдээлнэ.

SAMVAL: Олон нийтийн тайлангийн уншигчид хангалттай, холбогдох мэдээллээр хангах, тэдгээрийн танилцуулга тодорхой, зөв илэрхийлсэн, тайлан нь төөрөгдүүлэхгүй ойлгомжтой байна. Үйл явц, арга аргачал нь тухайн үнэлгээний зорилгод нийцсэн, бүх материалын хувьд хялбар аудит хийх боломжтой байна.

SME: [IMVAL Загвартай ижил байна]

[IMVAL Загвартай SME Удирдамж нь ижил байна]

VALMIN: Ил тод байдал нь олон нийтийн тайлан уншигчдийг тодорхой, зөв илэрхийлсэн хангалттай мэдээлэл, танилцуулгаар хангах, Материаллаг мэдээллийг орхигдуулахгүйгээр эсвэл мэдээлэлд төөрөгдөхгүй ойлгомжтой тайлан боловсруулахыг шаарддаг.

Олон нийтийн тайлан, үйл явц хоёр ил тод, объектив, нарийвчлалтай өгөгдөлтэй, мэргэжилтэн нь бусад материаллаг мэдээлэлээр хангагдсан байна. Олон нийтийн тайлангийн дүгнэлт нь Мэргэжилтэн нь үндэслэлтэйгээр мэдээлсэн гол таамаглалаас хамаарна.

Энэ нь (i) Ашигт малтмалын баялаг, хүдрийн нөөц, олборлолт, үйлдвэрлэл, баяжуулалт, зах зээлийн судалгаа, үнэлгээ, уурхайн хаалт, Эзэмшил газрын асуудлууд; (ii) Хувиргагч хүчин зүйлүүд; (iii) тохирох хандлагууд; (iv) ашигласан аргуудыг олон нийтийн тайланд тодорхой мэдээлэх ёстой. Хэрвээ тохирох тайлбарыг хийх боломжгүй бол, “Хэрвээ үгүй бол яагаад үгүй гэж” гэдгийг мэдээлэн, хийж гүйцэтгээгүй шалтгааныг тайлбарлана.

Объектив байдал

IMVAL: Үнэлгээчин нь үнэлгээнд объектив байдлаар хандана. Энэ нь өгөгдлийг баталгаажуулж, үнэлгээний явцад Үнэлгээчин нэг талыг баримтлах, субъектив хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах нөхцлийг бүрдүүлдэг (IVS Хамрах хүрээ, Заалт 40 Объектив).

"Үнэлгээний процесс нь үнэлгээчнийг баталгаатай өгөгдөл, таамаглалд үндэслэн шударгаар дүгнэхийг шаарддаг. Үнэлгээ нь итгэл үнэмшилтэй байхын тулд, үйл явц дахь субъектив хүчин зүйлсийг нөлөөг бууруулах, ил тод байдлыг дэмжих байдлаар дүгнэлт хийх нь чухал. Үнэлгээний дүгнэлт нь нэг талыг баримталсан дүн шинжилгээ, санал, дүгнэлт хийхээс зайлсхийж, объектив байдлыг хангана. (IVS Хамрах хүрээ, Заалт 40).

"Зохих стандарт, хяналт, зааврыг хэрэжүүлж, үнэлгээний явцад объектив байдлын шаардлагатай түвшинг хангах нь, үр дүн нь нэг талыг баримтлаагүй байх үндэс болно. Мэргэжлийн үнэлгээчний Ёс Зүйн Зарчмын IVSC код нь мэргэжлийн дүрмийн зохих хамрах хүрээний жишгийг хангана (IVS-ын Хамрах хүрээ, Заалт 40).

CIMVAL DRAFT: [Сүүлийн өгүүлбэр хасагдаж, “Үнэлгээчин”-ийг “Мэргэшсэн Үнэлгээчин”-ээр орлуулснаас бусад тохиолдолд, IMVAL Загвартай адил (IVS-аас харна уу).

[CIMVAL Удирдамж нь IMVAL Загвартай адил байна].

SAMVAL: Шударга байдал. Итгэмжлэгдсэн Үнэлгээчин (ИҮ) нь бүх таамаглал, анхдагч нөхцөл, хувиргах хүчин зүйлсийг баримтжуулсан тайлан олон нийтийн тайланг хийлгэхээр санаачилсан байгууллага, компани эсвэл хувь хүний нөлөөгүй байх, мэдээлэл бүхий уншигчдад үндэслэлтэй, тэнцвэртэй дүгнэлт гаргахад шаардагдах хангалттай материаллаг бүх мэдээлэл агуулсан ажлыг гүйцэтгэнэ.

SME: [3-р өгүүлбэрийг хассанаас бусад тохиолдолд IMVAL Загвартай адил байна (IVS Хамрах хүрээнээс харна уу)].

Үнэлгээчин нь үнэлгээнд шударга, хэт нэг талыг баримтлахгүй, объектив байдлаар хандана. Үнэлгээчин мэргэжлийн дүгнэлт гаргахдаа, үнэлгээчин нь өөрийн хувийн үзэл баримтлалаа хянах, үнэлгээ хийхдээ нэг талыг баримтлах нөлөөг бууруулна. Үнэлгээчин нь нь зохих стандарт, хяналт, зааврыг хэрэжүүлэх нь объектив байдлыг шаардлагатай түвшинд байлгаж, өгөгдөл, таамаглалын найдвартай байдлыг баталгаажуулна.

“Үнэлгээний явц нь үнэлгээчнийг баталгаатай өгөгдөл, таамаглалд шударга дүгнэлт хийхийг шаардана. Үнэлгээ нь итгэл үнэмшилтэй байхын тулд, үйл явцад субъектив хүчин зүйлүүдийг бууруулан, ил тод байдлыг дэмжиж дүгнэлт хийх нь чухал. Үнэлгээний дүгнэлт нь нэг талыг баримталсан дүн шинжилгээ, санал, дүгнэлтээс зайлсхийж, объектив байдлыг хангана.” (IVS-ын Хамрах хүрээ, §40.1).

“Мэргэжлийн Үнэлгээчний Ёс Зүйн Зарчим”-ын IVSC код нь мэргэжлийн үнэлгээчний дүрмийн зохих хамрах хүрээг хангана (IVS-ын Хамрах хүрээ, Бүлэг 40).

VALMIN: [дурдаагүй]

Хараат бус байдал

IMVAL: Тодорхой үнэлгээнд, Хараат бус байдлыг хууль, үндэсний код, стандарт, эсвэл Үнэлгээний нөхцөл байдлын хүрээнд шаардана. Эдгээр нөхцөлд, Хараат бус байдал гэдэг нь Үнэлгээнд хамааралтай нөхөн олговор болон мэргэжлийн төлбөрөөс бусад тохиолдолд Мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгийг үнэлүүлж байгаа үйлчлүүлэгч, Ашигт малтмалын хөрөнгийн хэлцэлд оролцогч бусад талууд, эсвэл Үнэлгээний үр дүнд мөнгөн эсвэл хувийн ашгийн сонирхолгүй байх.

Олон улсын үнэлгээний стандарт, загвар нь Үнэлгээчний Хараат бус байдлыг нарийвчлан заагаагүйч олон улсын эрх зүйн, үндэсний хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын дагуу үйлчлүүлэгч байгууллага эсвэл зорилтот хэрэглэгчдэд зориулан тусгайлан зааж болно.

Мэргэжилтэн нь нэг талыг баримтлаагүй, хэрэглэгчид нь итгэлтэйгээр хүлээн зөвшөөрөх Үнэлгээг хийх чадвартай байна, Мэргэжилтэн нь Үнэлгээний үр дүнгээс хараат бус, дүгнэлтийг объектив хийх ёстой.

CIMVAL DRAFT: Тодорхой үнэлгээнд, Мэргэшсэн үнэлгээчний Хараат бус байдлыг үндэсний код, стандарт, эсвэл Үнэлгээний нөхцөл байдлын хүрээнд шаардана.

Мэргэшсэн Үнэлгээчин нь нэг талыг баримтлаагүй, хэрэглэгчид нь баттайгаар хүлээн зөвшөөрөх үнэлгээг хийх чадвартай байна, Мэргэшсэн Үнэлгээчин нь Үнэлгээний үр дүнгээс хараат бус, дүгнэлт нь объектив байх шаардлагатай.

SAMVAL: *Зарим нөхцөлд, Үйлчлүүлэгч байгууллага нь Итгэмжлэгдсэн Үнэлгээчдийг хараат бус байдлаа харуулах, олон нийтэд мэдээлэхийг шаардаж болно.*

Хараат бус байдал нь зарим нөхцөлд, Ашигт малтмалын Хөрөнгийн Үнэлгээтэй холбоотой мэргэжлийн төлбөр, нөхөн олговор хүлээн авахаас бусдаар, Мэргэжсэн Үнэлгээчин нь Ашигт малтмалын үнэлгээнээс мөнгөн болон хувийн ашгийн сонирхолгүй, Үйлчлүүлэгч байгууллага эсвэл Ашигт малтмалын төслийн эрх эзэмшигчтэй холбоотой байгаа нь үнэлгээ субъектив, хэт нэг талыг баримталсан үзэж болно. Мэргэжсэн үнэлгээчин нь үнэлгээ, тайлангийн хэлцлийн үр дүнгийн дараа мөнгөн урамшил хүлээн аваагүй талаар мэдээлнэ.

Хэрвээ шаардлагатай бол, Мэргэжсэн үнэлгээчин нь өөрийн хараат бус байдал, мөн үйлчлүүлэгч байгууллагатай харилцаа холбоотой талаар бичгээр нийтэд мэдээлнэ.

SME: [IMVAL Загвартай ижил]

["the SME Valuation Standards"-ын 1-р өгүүлбрийг "the Template"-ээр орлуулснаас бусад тохиолдолд, SME Удирдамж нь IMVAL Загвартай ижил]

VALMIN: *Хараат бус байдал, Хараат бус байх Ашигт малтмалын хөрөнгийн хувьд урьдчилан харсан ашиг сонирхолгүй байхыг шаарддаг, эсвэл Үйлчлүүлэгч этгээд, оролцогч талууд холбоотой нь хэт нэг талын баримтлалтай байж болзошгүй гэж үзнэ. Хараат бус байдлын, хараат бус байх эрх зүйн нэр томъёонд дурдсанаас ялгаатай боловч, хуулийн заалтад давуу эрх олгоно. Хараат бус байдал нь VALMIN Кодын дагуу албан ёсны шаардлага биш. Гэсэн хэдийч, Мэргэжилтэн нь харьяа газрын хууль, дүрэм журмын дагуу хараат бус байдлын шаардлага, тодорхойлолтыг дагаж мөрдөж, мэдэх ёстой.*

Компаний акт, Австралийн Үнэт цаас, Хөрөнгө оруулалтын хороо (ASIC)-ны Эрх зүйн зохицуулалтын удирдамжид Мэргэжилтэн нь тодорхой худалдааны хэлцлүүдэд зориулан хийсэн үнэлгээний тайлангууд нь Хараат бус байх ёстойг заасан. Мөн, AFSL лиценз эзэмшигч нь удирдлагын зөрчлийг зохицуулах заалтуудыг мөрдөх ёстой.

ASIC нь Эксперийн бие даасан байдлыг, ASIC Эрх зүйн зохицуулалтын Удирдамж RG 112-ийн дагуу мэдээлэхийг тодорхойлно. Хараат бус байдлын мэдэгдлийг дэмжихийн тулд, Мэргэжилтэн үнэлгээ хийх чадамж, Бие даасан бус эсэх, ямар нэгэн ашиг сонирхол, хараат бус байх тохиролцоо байгаа эсэх талаар олон нийтийн тайланд мэдүүлнэ.

Олон нийтийн мэдүүлэг гэдэг нь:

- (i) Үйлчлүүлэгч байгууллага нь аль болох эрт мэдүүлэх
- (ii) Олон нийтийн тайланд нээлттэйгээр мэдээлэх
- (iii) Мэргэжилтэн нь тухайн үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгөд өмнө нь үнэлгээний тайлан хийсэн эсэхийг мэдүүлэх
- (iv) Мэргэжилтнийг хараат бус байх ямар нэгэн хууль, эрх зүйн шаардлагаас чөлөөлөөгүй талаар,

Мэргэжилтэн нь үйлчлүүлэгч байгууллаг, хамаарал бүхий талуудтай холбоотой байсан нь бие даасан байдалд нөлөөлөхгүй байна. Тухайн нөхцөл бүрт үнэлгээ өгч, баримтжуулна.

Үндэслэл

IMVAL: *Үнэлгээчин нь Үнэлгээний үндэслэлтэй байдалд баталгаа өгөх ёстой. Аливаа үнэлгээнд хэрэглэсэн таамаглал, хамаарах арга аргачлал нь үнэлгээний зорилго, үнэ цэнийн суурийн нөхцөлд үндэслэлтэй байна.*

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд хэрэглэж байгаа арга нь тухайн хөрөнгийн түрээслэгч, худалдан авагчийн таамаглал, тооцоолж буюу чадамжид нийцсэн байна. IVS 104 Үнэ цэнийн суурь, Заалт 200 Таамаглал ба Тусгай таамаглалууд.

Үндэслэлтэй шалгуур нь зохих мэргэшсэн, туршлагатай үнэлгээчин нь үндэслэлтэйгээр нөхцөл байдлыг дүгнэнэ. Үнэлгээчин нь нөхцөл байдлын талаар үзэл санаагаа үндэслэлтэй илэрхийлэх ёстой бөгөөд, нөхцөл байдалд оновчтой, итгэл үнэмшилтэй байж, ижил цаг хугацаанд ижил мэдээлэлтэй бусад мэргэшсэн, туршлагатай Үнэлгээчний үзэл бодлыг авч үзэж болно.

CIMVAL DRAFT: Мэргэшсэн Үнэлгээчин нь Үнэлгээг үндэслэлтэй байдалд баталгаа өгөх ёстой.

Аливаа үнэлгээнд хэрэглэж буй таамаглал, арга аргачлал нь үнэлгээний зорилгын хүрээнд, үнэ цэнийн суурь байна.

Үндэслэлийн тест тухайн мэргэшсэн, туршлагатай үнэлгээчин, нөхцөл байдлыг ул суурьтай авч үзэн дүгнэх. Мэргэшсэн Үнэлгээчин нь нөхцөл байдлын талаар үзэл санаа нь ул суурьтай байх ёстой, үнэлгээчин нь нөхцөл байдалд оновчтой, итгэл үнэмшилтэй, ижил мэдээлэл, ижил цаг хугацаанд бусад мэргэшсэн, туршлагатай Үнэлгээчнээр үзэл бодлыг авч үзэж болно.

SAMVAL: Үндэслэлтэй байдал нь бусад зохих мэргэшсэн, туршлагатай Итгэмжлэгдсэн Үнэлгээчин нь ижил цаг хугацаанд ижил мэдээлэл авах боломжтой, ижил ажлын хүрээнд ижил үнэ цэнийн суурийг ашиглан, өргөн хүрээний харьцуулсан үнэ цэнийн хэлбэлзлийг тооцно.

Үндэслэлтэй байдлын тест нь салбарын стандарт, нормын дагуу үнэлгээг мэдэх зорилгоор хийдэг. Хэрвээ үнэ цэнийн суурь нь зах зээлийн үнэ цэнэ байвал, тухайн таамаглал, тухайн хөрөнгийн хөгжлийн үе шатын арга аргачлал, моделиос хамааран, үнэлгээний зорилгод нийцсэн үндэслэлтэй байна. Хөгжлийн үе шатын аргачлал, модель нь хүлээгдэж байгаа хэмжээнд, Ашигт малтмалын хөрөнгийн худалдан авагчийг харгалзан үзсэн байна.

SME: [Дурдаагүй]

VALMIN: Үндэслэлтэй байдал нь Үнэлгээнд ашиглаж байгаа өгөгдлийн боловсруулалт нь шударга, бодитой, логик дараалалтай, ижил мэдээлэл бүхий бусад Үнэлгээчид ижил Үнэлгээг хийж болно.

Үндэслэлтэй байдлын тест нь Мэргэжилтэн нь (i) ерөнхий үнэлгээний хандлага, үнэлгээний аргачлал, үнэлгээ нь үндэслэлтэй байгааг тодорхойлох боломжтой бодит үнэлгээг хийх. Үндэслэлтэй байдлын тест нь салбарын стандарт, нормын дагуу байгааг үнэлгээг мэдэх зорилгоор хийдэг; (ii) Үндэслэлтэй байдлын шалгуурт нийцсэн эсэх; (iii) Үндэслэлтэй байдлын шалгуурт нийцүүлэн, үнэлгээ, үнэлгээний арга аргачлал, үнэлгээний хандлага, өгөгдөл, таамаглалууд эерэг мэдэгдлийг хийх; (iv) Ашиглаж буй Үнэлгээ, үнэлгээний арга аргачлал, үнэлгээний хандлагын хариуцлагыг мэдэж, зөвшөөрөх;

Эерэг мэдэгдэл, татгалзах мэдэгдэл хийх удирдамжын талаар ASIC Зохицуулалтын заавар RG111, RG170, ASIC Мэдээллийн хуудас 214-аас татаж авна. (Уул уурхай, нөөц – алсыг харсан мэдэгдэл).

Үндэслэлтэй байдлын тест нь объектив байхад оршино. Компаний тухай акт, Австралийн Үнэт цаас, Хөрөнгө оруулалтын Хорооны Актуудын заалтуудад ирээдүйд болох үйл явдлын талаар мэдэгдэл хийхдээ, тухайн цаг хугацаанд мэдэгдэл нь үндэслэлтэй байх, төөрөгдөлд оруулахгүй байна.

Үндэслэлтэй байдлын шалгуурыг Компаний тухай актын заалт 670A(2), 728(2), 769(C), Австралийн Үнэт цаас, Хөрөнгө оруулалтын Хорооны Актуудын заалт 12BB, ASIC Мэдээллийн хуудас 214-аас заавраас харж болно.

Үндэслэлтэй байдлын шалгуурыг одоогийн эсвэл хэтийн төлөвтэй эрдэсжилт, мөн хувиргалтын хүчин зүйлүүдээр тайлбарлана. Тохирох объектив үндэслэлтэй байдлын тестийг хэрэглээгүй бол, Олон нийтийн тайланд нийтлэхгүй.

ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

IMVAL: Үнэлгээний тайланд хамгийн бага түвшинд дараахи мэдээллийг агуулна. (IVS 103 Тайлагнах):

Хөрөнгийн үнэлгээ, сонирхолын тодорхойлолт

IMVAL: Ашигт малтмалын хөрөнгийн хувьд эрх эсвэл сонирхол нь Үнэлгээний субъект байна, үнэлгээтэй холбогдуулан гадаад шинж чанар, хууль эрх зүй, эдийн засгийн шинж чанараар нь хөрөнгийг тодорхойлон, дэлгэрэнгүй тайлбарласан байна. Тодорхойлолт нь Үнэлгээний субъект нь эдийн засгийн талаасаа бусад хөрөнгүүдтэй хоорондоо хамааралтай тохиолдолд Үнэлгээний таамаглал хийхдээ бусад хөрөнгүүдийн хамт үлдээх, үгүйг мэдээлнэ.

Нэг болон хэд хэдэн газрын зургууд, фото графикууд, диаграмуудаар Ашигт малтмалын Хөрөнгийн тодорхойлох боломжтой. Баталгаажуулах зорилгоор Тусгай зөвшөөрөл, эрх, саад бэрхшээлийн баримтжуулан Үнэлгээний тайланд оруулна. Үнэлгээнд оруулаагүй хэсэгчилсэн хувь, эд хөрөнгийн хувь, хэсэгчилсэн эзэмшил, эзэмшил болон хяналтын хязгаарлалтын тайлбар, хөрөнгө, эрх зөвшөөрлүүд байгаа тохиолдолд, тодруулга хийх шаардлагатай. Жишээ нь, алслагдсан ашигт малтмалын ордын баяжуулах үйлдвэр нь хяналтад байх боловч, уурхайн каймпийн баяжуулах үйлвэр нь хяналтаас гадуур байж болно.

CIMVAL DRAFT: [1-р өгүүлбэр IMVAL Загвартай ижил]. 2-р өгүүлбэр: Тодорхойлолт нь Үнэлгээний субъект эдийн засгийн талаасаа бусад хөрөнгүүдтэй хоорондоо хамааралтай тохиолдолд Үнэлгээнд ашигласан таамаглалыг мэдээлэх шаардлагатай.

[CIMVAL Төсөл Удирдамж нь IMVAL Загвартай ижил]

SAMVAL: Хөрөнгийн төрөл, Эзэмшигчийн сонирхол. Ашигт малтмалын эрх, үүнд ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлийг Өмнөд Африкт үнэлгээ хийхэд “хязгаарлагдмал бодит зөвшөөрөл” гэж ойлгоно. “Бодит зөвшөөрөл” гэж ерөнхийд нь хэлнэ.

Ашигт малтмалын зөвшөөрлийн статус, гэрээнүүд, бусад эзэмшигчтэй холбоотой асуудлууд нь хувиргагч хүчин зүйлүүд бөгөөд эдгээр нь ерөнхий үнэлгээнд нөлөөтэй, хамрах хүрээнд орно. Үйлчлүүлэгч хуулийн этгээдийн хариуцлага, тэдгээрийн сонирхлыг олон нийтэд мэдээлэх ба, Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь эзэмшигчтэй холбоотой асуудлыг харгалзан үнэлгээг хийнэ. Ашигт малтмалын зөвшөөрлийг эзэмшиж байгаа тохиолдолд, Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь зөвшөөрөлтэй холбоотой ямар нэгэн хязгаарлалт, нөхцлүүд байгаа эсэх, тэдгээр нь үнэ цэнэд нөлөөлөх, тухайн газрын хараат байдал, түрээс, гэрээ зэргийг харгалзан авч үзнэ.

Эрх зөвшөөрөл, гэрээний хэлцэл. Итгэмжлэгдсэн Үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийн эзэмшигчийн статусыг магадлан шалгана. Ялангуяа, тухайн хөрөнгө нь үл хөдлөх хөрөнгийн эзэмших эрх, зөвшөөрөлтэй бол, тэдгээр зөвшөөрөл, хэлцлүүд нь

үнэлгээнд хэрхэн нөлөөлөх эсэхийг магадлана. Эдгээрт эдэлбэр газрын аюулгүй байдал, зөвшөөрөл, дарамт шахалт, роялти төлбөрүүд, хамтын үйл ажиллагаатай холбоотой асуудлуудыг багтаана. Хэрвээ үнэлгээнд хамааруулан газрын үнэлгээг хийвэл, энэ нь хөрөнгөтэй хамааралтай эсэх, эсвэл түрээсийг төлсөн эсэх үнэлгээг хийнэ.

SME: [IMVAL Загвартай ижил]

[SME Удирдамж нь IMVAL Загвартай ижил]

VALMIN: Эзэмшигчийн байдал. Эзэмшигчийн байдал материаллаг байх бөгөөд мэдээлэх шаардлагатай. Эзэмшигчийн байдлыг тодорхойлох зайлшгүй шаардлагатай бөгөөд, олон нийтийн тайлангийн зорилго, асуулгад нийцүүлэн мэдээллийг хангалттай үнэн зөв сүүлийн үеийн лавлагаа, мэдээлэл дээр үндэслэнэ.

Мэргэжилтэн лавлагааг мэргэжилтэн, эсвэл тохирох мэргэжсэн этгээдээр хийлгэх, Эзэмшигч нь материаллаг гэж үзвэл, сүүлийн үеийн мэдээлэл нь хараат бус Үйлчлүүлэгч хуулийн этгээдээр баталгаажсныг тодорхойлно.

Бусад дагалдах тайланд мэдээлэл нь ороогүй бол, Олон нийтийн тайланд бүх өмчийн жагсаалтыг эсвэл тухайн үнэлгээчний нэрийн өмнөөс үүнийг бэлтгэж оруулна.

Эзэмшлийн жагсаалтыг дараахи байдлаар тусгайлан мэдээлнэ:

- a) Эзэмшлийн талбай, дуусах дахин сунгах хугацаа,
- b) Зарцуулсан зардлууд, түрээс, тариф, үнэт цаасны бонд, байгаль орчны төлбөр
- c) Гуравдагч этгээдэд хэрвээ хязгаарлагдаагүй бол хамтын хөрөнгө оруулалт, роялти гэрээ, үүрэг хүлээсэн эсэх,
- d) Үнэлгээчний хувьд, өмчтөй холбоотой геологийн болон зэргэлдээ байршилд, материаллаг байдлаар өмчийн үнэ цэнэд оруулахаар харгалзан үзнэ.

Ажлын хамрах хүрээ

IMVAL: Үнэлгээний гүйцэтгэх ажлын хамрах хүрээг, нууц биш бол, үнэлгээчин болон үйлчлүүлэгч байгууллагын хооронд тодорхойлон хийнэ. Итгэл үнэмшил бүхий үнэлгээний шаардлагатай ажлын хамрах хүрээ нь тухайн ашигт малтмалын хөрөнгийн шинж чанар, үнэлгээний зорилго, үнэ цэнийн суурь, үнэлгээний огноо, Үнэлгээний зориулалтаас хамаараад өөр өөр байна. Үнэлгээний явцад ажлын хамрах хүрээний өөрчлөлт хийх шаардлага гарч болно. Үнэлгээний тайланд ажлын хамрах хүрээг судалгааны гүйцэтгэлийн тайлбар, тухайн судалгааны хязгаарлалтын мэдээллийг оруулна. (IVS 101 Ажлын хамрах хүрээг харна уу)

CIMVAL DRAFT: [“Нууц эсэх” устгасанаас бусдаар, 1-р өгүүлбэр нь IMVAL Загвартай ижил,]. 2, 3 -р өгүүлбэрүүд нь IMVAL загвартай ижил. 4-р өгүүлбэр: “Үнэлгээний тайлангийн ажлын хамрах хүрээнд судалгааны гүйцэтгэлийг тайлбарлах, судалгааны хязгаарлалтуудыг мэдэгдэх. (IVS 101 Ажлын хамрах хүрээг харна уу)”]

Үнэлгээ хийх (хэсэг). Үйлчлүүлэгч байгууллага, Мэргэшсэн үнэлгээчин нь ажлын даалгаврыг урьдчилаад бичгээр тохиролцон, Үнэлгээний даалгаврын ажлын хамрах хүрээ, нөхцлийн талаар үнэлгээний тайланд хураангуйлан мэдээлнэ.

SAMVAL: Үнэлгээний хэрэглээний хязгаарлалт. Үнэлгээний хэрэглээний хязгаарлалтыг Үйлчлүүлэгч, Итгэмжлэгдсэн үнэлгээчинтэй зөвлөлдөн тодорхойлно. Үнэлгээний зорилгыг тодорхой тусгана. Тухайн үнэлгээний тусгай зориулалт, тухайн хугацаа огноо нь бусад зориулалтад тохиромжгүй ба/эсвэл дараагийн цаг хугацаанд ашиглах боломжгүйг мэдэж байх нь уншигчдын үүрэг хариуцлага.

Тухайн баримт бичиг нь тодорхойгүй мэдэгдэл зорилго агуулсан бол тухайн Ашигт малтмалын үнэлгээний хэрэглээнд хязгаарлалт байна. Үнэлгээний дараагийн хязгаарлалт нь хүчин төгөлдөр хугацаандаа хүчинтэй байна.

Үйлчлүүлэгч байгууллага (хэсэг). Үйлчлүүлэгч байгууллага, Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь үнэлгээний даалгаврын нөхцөл, үнэлгээний тайланд хураангуйлан оруулах нөхцлүүдийг ажил гүйцэтгэх гэрээ болон бичгээр тохиролцсон байна. Гэвч энэ нь итгэмжлэгдсэн үнэлгээчин тохиромжтой гэж үзсэнээс бусад тохиолдолд үнэлгээнд нөлөөлөхгүй, нэг талыг баримтлахгүй байна. Ажлын даалгаврын зорилго, зорилго, ашиглах боломж, мэдээллийн шаардлагууд, бусад холбогдох таамаглалууд, урьдчилсан нөхцлүүд, эсвэл ажлын даалгавартай холбоотой бэрхшээлүүдийг мэдээлэнэ.

SME: [1, 2 -р өгүүлбэр нь IMVAL Загвартай адил. 3-р өгүүлбэр: “Ажлын хамрах хүрээний хувиргалтууд үнэлгээ хийх явцад мэдэгдэнэ”. 4-р өгүүлбэр нь IMVAL Загвартай адил. IMVAL Загварын 5-р өгүүлбэрийг хассан (IVS-аас харна уу)]

VALMIN: Үйлчлүүлэгчтэй бичгээр хийсэн гэрээнд Олон нийтийн тайлангийн зорилго, хамрах хүрээг тусгана.

Гэрээнд дараахи асуудлуудыг авч үзэх боловч, үүгээр хязгаарлагдахгүй.

- a) *Олон нийтийн тайлангийн зорилго;*
- b) *Мэргэжилтний нэр (с), мэргэшил, холбогдох туршлага;*
- c) *Мэргэжилтний Хараат бус байдал, Мэргэжлийн байдлын баталгаа;*
- d) *Үйлчлүүлэгч байгууллага, Мэргэжилтэн хүлээн зөвшөөрсөн Хүчин төгөлдөр хугацаа;*
- e) *Олон нийтийн болон Ашигт малтмалын хөрөнгийн тайлангийн нэр эсвэл гарчиг*
- f) *Олон нийтийн тайлангийн зардлын суурь*
- g) *Хэрвээ хангалттай нарийвчлалтай дата, мэдээлэл авах боломжгүй тохиолдолд, Мэргэжилтэн нь дүгнэлт эсвэл тайлан өгөхөөс татгалзаж болно;*
- h) *Хараат бус Шинжээчийн тайланд, Мэргэжилтэн нь олон нийтийн тайланд зарим чиглэлээр гэрээний нөхцлийн дагуу оролцож болно.*
- i) *Үйлчлүүлэгчийн өгсөн мэдээлэл, судалгааны үр дүнд мэдлэг мэдээлэл олох нь Мэргэжилтэн өөрийн эрх, үүрэг хариуцлага;*
- j) *Мэргэжилтэн нь VALMIN Кодыг дагаж мөрдөх, үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрөх;*
- k) *Олон нийтийн тайланд боловсруулалт, гүйцэтгэл дуусах хөтөлбөрт завсрын үйл ажиллагаа дуусах хугацаа, Үйлчлүүлэгчийн мэдээлэл, өгөгдлийн дүгнэлт, Мэргэжилтэн өгөгдлийн мэдээллийн нөхцөл байдал, Олон нийтийн тайланг Үйлчлүүлэгчид өгөх хугацааг оруулна;*
- l) *Мэргэжилтэн нь Үйлчлүүлэгч байгууллагатай хэлэлцсэн асуудлын талаархи тэмдэглэл хөтөлсөн талаар мэдээлэх, Олон нийтийн тайланд хамааралтай баримтуудын жагсаалт, бүх материалын эх үүсвэрийн хуулбарууд, хяналт шалгалтын тайлангийн тэмдэглэл гэх мэт*
- m) *Үйлчлүүлэгчийн баримт материалын шалгалтад зориулж төсөл тайланг бэлтгэх,*

Тэмдэглэл хөтлөх, төсөл тайлангийн удирдамжийг ASIC Зохицуулах удирдамж RG 112- аас харна уу (Тухайн кодын огнооноор).

Зорилтот хэрэглээ, зорилтот хэрэглэгч

IMVAL: Үнэлгээний зориулалт, зорилтот хэрэглэгчийн талаар хэрвээ нууцлалгүй бол, тодорхой мэдээлэх ёстой.

CIMVAL DRAFT: ["нууцлалгүй" хассанаас бусад тохиолдолд, IMVAL Загвартай адил]

SAMVAL: [дурдаагүй]

SME: [IMVAL Загвартай адил]

VALMIN: [дурдаагүй]

Ашигт малтмалын баялаг, нөөц

IMVAL: Ашигт малтмалын хөрөнгийн нөөц, баялгийг хэрэглэх, эсвэл Үнэлгээний тайланд, үнэлгээнд эдгээрийг хэрэглэх тохиолдолд, CRIRSCO-д суурилсан код, эсвэл хамтын институтын Ашигт малтмалын нөөц, баялгийн тодорхойлолт, эсвэл Газрын тосны нөхцөлд Газрын Тосны Нөөцийн Менежментийн Систем (PRMS)-ийн тодорхойлолтын дагуу Газрын тосны баялаг, Газрын тосны нөөцийн тодорхойлолтыг хэрэглэнэ. Хэрвээ CRIRSCO эсвэл PRMS системүүдийг хэрэглээгүй бол, тухайн үнэлгээний тайланд яагаад хэрэглээгүйг тайлбарлах ёстой, CRIRSCO эсвэл PRMS – ийн дагуу баялаг, нөөцийг нэгтгэн дүйцүүлэх боломжтой.

CIMVAL DRAFT: Ашигт малтмалын хөрөнгийн нөөц, баялгийг хэрэглэх, эсвэл Үнэлгээний тайланд, үнэлгээнд эдгээрийг хэрэглэх тохиолдолд, CRIRSCO- кодын тодорхойлолтод дүйцэх эсвэл одоогийн, CIM Стандартын дагуу тодорхойлсон Ашигт малтмалын нөөц, баялгийг хэрэглэнэ. Хэрвээ Үнэлгээний тайланд Канадын улсын бус, бусад орны нөөц, баялгийн тооцоо нь CIM Стандарт, CRIRSCO кодын нөөц баялгийн тодорхойлолтод нийцээгүй бол, өмнөх тооцооллыг NI 43-101-ын Бүлэг 2.4, мөн бусад хүлээн зөвшөөрөх гадаад орны кодын дагуу тооцох талаар NI 43-101-ын Бүлэг 7.1 -ын дагуу мэдээлэх ёстой. Тухайн үнэлгээний, техникийн тайлан хийхдээ Эрдэс баялаг, нөөцийн чиглэлээр Мэргэшсэн мэргэжилтнээр (CIM тодорхойлолт, стандартад тодорхойлсноор) нэгтгэсэн нөөц, баялгийг ашиглах.

SAMVAL: SAMVAL үнэлгээ нь SAMREC -ын Нөөц, баялагийн ангилалд үндэслэх эсвэл CRIRSCO-д гишүүнчлэлтэй Эрдэс баялаг, нөөц тайлагнах бусад кодоод тулгуурлахыг Үйлчлүүлэгч байгууллага, холбогдох харьяалах эрх зүйн хүрээнд шаардана. Тиймээс, Үнэлгээний тайлан нь үнэлгээтэй хамааралтай код, тухайн кодыг ашиглах үндэслэлийг заана.

SME: Ашигт малтмалын хөрөнгийн нөөц, баялгийг хэрэглэх, эсвэл Үнэлгээний тайланд, үнэлгээнд эдгээрийг хэрэглэх тохиолдолд, *The SME Эрдэс баялгийн нөөц, Хайгуулын ажлын үр дүнгийн тайлагнах удирдамж, тодорхойлолт (The SME Удирдамж), CRIRSCO-ын Олон улсын тайлангийн загвар, тодорхойлолтууд, эсвэл Газрын тосны нөхцөлд, Газрын тосны нөөцийн Менежментийн Систем (PRMS)-ийн тодорхойлолтуудыг дагаж мөрдөнө.* Хэрвээ CRIRSCO эсвэл PRMS систем зэргийг хэрэглээгүй бол, тухайн үнэлгээний тайланд яагаад хэрэглээгүйг тайлбарлах ёстой, CRIRSCO эсвэл PRMS – ийн дагуу баялаг, нөөцийг нэгтгэн дүйцүүлэх боломжтой.

VALMIN: The JORC код нь Австралийн хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын нөөц, баялгийн удирдамж, зөвөлгөө, стандартын хамгийн бага хэмжээг тогтооно.

Австралийн Үнэт цаасны бирж нь Үнэт цаасны журмын 5-р зүйлийн JORC код гэж зааснаар, тухайн олон нийтийн тайланг Хайгуулын ажлын үр дүн, Эрдэс баялаг, нөөцийн JORC кодын дагуу хийсэн байхыг шаардан, хууль ёсны дагуу бүртгэдэг.

JORC кодоод the AusIMM болон AIG гишүүд хамааралтай байна.

Нэмэлт мэдээллийг <http://www.jorc.org> -аас харна уу.

Хамгийн үр ашигтай хэрэглээ

IMVAL: Ашигт малтмалын хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг тухайн үнэлгээний хугацаанд, хамгийн үр ашигтай хэрэглээг харгалзан тооцоолсон байх ёстой (тухайн хөгжлийн үе шатанд). Хөрөнгийн хамгийн үр ашигтай хэрэглээ нь тухайн шатандаа (1) хууль ёсны, (2) биет шинж чанраараа боломжтой, (3) тухайн үнэлгээний цаг хугацаанд санхүүгийн хувьд боломжтой, (4) тухайн Ашигт малтмалын хөрөнгийн хүчин чадлыг хамгийн дээд хэмжээнд байхаар тодорхойлно. Ашигт малтмалын хөрөнгийн хамгийн сайн хэрэглээг тооцоходоо тухайн хөрөнгийн зах зээлд оролцогчоор төсөөлөн, одоогийн хэрэглээ, тухайн хэрэглээний өөрчлөлт, өөр хэрэглээг тооцоолон тухайн хөрөнгийн хамгийн дээд үнийг тогтооно. Хэрвээ эдийн засгийн хувьд хоорондоо харилцан хамааралтай олон хөрөнгүүдээс тусдаа үнэлэгдсэн бол ашигт малтмалын хөрөнгийн хамгийн үр ашигтай хэрэглээ нь өөрчлөгдөж болно. IVS 104 Үнэ цэнийн суурь, Бүлэг 140, үнэ цэнийн нөхцөл - хамгийн үр ашигтай хэрэглээг харна уу.

Тодорхой эрх зүйн харьяалалын хүрээнд, ашигт малтмалын хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг хамгийн үр ашигтай хэрэглээг харгалзан үзэж тооцохыг шаарддаггүй. IVS 104 Үнэ цэнийн суурь, Бүлэг 140, үнэ цэнийн нөхцөл- хамгийн үр ашигтай хэрэглээг харна уу.

CIMVAL DRAFT: [дурдаагүй]

SAMVAL: [дурдаагүй]

SME: [1-р өгүүлбэр: “Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, үнэ цэнийн суурь нь зах зээлийн үнэ цэнэ бөгөөд, энэ нь тухайн үнэлгээний хугацаанд, тухайн хөрөнгийн хамгийн үр ашигтай хэрэглээг (ерөнхий хөгжлийн үе шат) харгалзан тооцоолсон байх ёстой,” бусдаар, IMVAL Загвартай адил.] Сүүлийн өгүүлбрийг (IVS 104-аас лавлах) устгасан.

VALMIN: [дурдаагүй]

Үнэ цэнийн суурь

IMVAL: Үнэлгээний тайланд үнэ цэнийн суурь, түүний тодорхойлолт, тодорхойлолтын эх үүсвэрийг ойлгомжтой тусгах ёстой. IVS 104 Үнэ цэнийн суурь-аас харна уу.

CIMVAL DRAFT: [2-р өгүүлбэрийг хассанаас бусад тохиолдолд, IMVAL Загвартай адил]

SAMVAL: Үнэлгээний суурь нь үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгийн мөнгөн үнэ цэнэ юм. Энэ нь үнэлгээний үнэ цэнийн төрлөөс хамаараад өөр байж болно.

Олборлох салбарт, үнэ цэнийг үнэлж байгаа хөрөнгийн өвөрмөц техникийн шинж чанар бүхий “хөрөнгийн бодит (тооцсон) үнэ цэнэ” - нээс гаргана. Хэрвээ өөр бусад үнэ цэнийн төрлийг хэрэглэсэн, эсвэл шаардлагатай бол, тодорхой тайлбарыг Итгэмжлэгдсэн Үнэлгээчин үнэлгээний тайланд тодотгож мэдээлнэ. Энэ нь ялангуяа Зах зээлийн (Market) үнэ цэнэ эсвэл Бодит (Fair) үнэ цэнийн нөхцөлд шаардлагатай байдаг. Бодит үнэ цэнийг Зах зээлийн үнэ цэнэ рүү шилжүүлэн хувиргахын тулд, тохирох үндэслэлтэй зах зээлийн хүчин зүйлсийг хэрэглэнэ.

SME: [2-р өгүүлбэрийг хассанаас бусад тохиолдолд, IMVAL Загвартай адил (IVS Хамрах хүрээнээс лавлана уу)]

VALMIN: Олон нийтийн тайланд үнэ цэнийн суурийг мэдээлнэ. Үнэ цэнийн суурь нь үнэлгээний үндсэн таамаглал хэмжээсүүдийн илэрхийлэл.

VALMIN код нь Зах зээлийн үнэ цэнэ, Техникийн үнэ цэнэ гэсэн үндсэн нэр томъёонуудыг хэрэглэдэг боловч, нөхцөл байдлаас хамааран өөр тодорхойлолтыг хэрэглэхийг шаардаж болно.

Техникийн үнэ цэнэ нь Үнэлгээчний тохиромжтой гэж дэвшүүлсэн таамаглалд суурилсан, нэмэгдэл болон хорогдуулалт тооцохгүйгээр зах зээлийн нөхцлийг харгалзан, тухайн цаг хугацааны Ашигт малтмалын хөрөнгийн ирээдүйн эдийн засгийн цэвэр үр ашгийн тооцоолол юм.

Техникийн үнэ цэнийн нэр томъёо нь IVSC-ийн Хөрөнгө оруулалтын үнэ цэнийн нэр томъёотой ижилхэн зорилго, агуулгатай.

Зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлд, талууд нь мэдээлэлтэй, албадлагагүй, хараат бус худалдааны хэлэлцээрээр, авахыг хүссэн худалдан авагч, зарахыг хүссэн худалдаачин хоорондын тухайн өдрийн Ашигт малтмалын хөрөнгийн арилжаа, тооцоолсон дүн (зарим хэлцэлд мөнгөтэй адилтгах зүйлс) юм.

Зах зээлийн (Market) үнэ цэнийн нэр томъёо нь IVSC - нэр томъёотой ижил нэр , ижил зорилго бүхий утгатай. Энэ нь Бодит (Fair) үнэ цэнэтэй RG111 дагуу ижил утга агуулна. VALMIN кодын 2005 ойн хувилбараар Бодит Зах Зээлийн Үнэ Цэнэ гэж тодорхойлсон.

Зах зээлийн үнэ цэнэ нь Техникийн үнэ цэнээс их эсвэл бага байж болно. Олон нийтийн тайланд тооцсон хүчин зүйлүүд, гол үнэлгээний арга аргачлалын үр дүн, Техникийн үнэ цэнэ болон Зах зээлийн үнэ цэнийн хоорондын ялгаа, шалтгаан, нийт дүнгийн талаар мэдээлнэ. Үнэлгээний тайланд тодорхойлсон үнэ цэнийн төрөл, үнэлгээний цаг хугацааг мэдээлэх ёстой.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэ цэнэ нь цаг хугацааны туршид хэлбэлзэх хандлагатай байдаг учраас, Мэртухайн үнэлгээний цаг хугацааны нөхцөлд нийцсэн үнэлгээг хийн, дүгнэлтээ илэрхийлж баталгаажуулах ёстой.

Үнэлгээний хандлагууд

IMVAL: Нэг болон түүнээс дээш үнэлгээний хандлага Ашигт малтмалын хөрөнгийг үнэлэхэд хэрэглэнэ, хэрвээ шаардлагатай, тохиромжтой гэж үзвэл, Үйлчлүүлэгчтэй тохирсон ажлын хамрах хүрээтэй зөрчилдөхгүй бол, тэдгээрийг хэрэглэж болно. Үнэлгээний үр дүнгийн тооцооллыг нийцүүлж нэгтгэнэ. Хэрвээ нэг хандлага хэрэглэсэн тохиолдолд, Үнэлгээний тайланд яагаад нэгээс илүү хандлагууд хэрэглээгүй шалтгааныг мэдээлнэ. IVS 105 Үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, Бүлэг 10 Танилцуулга -хэсгээс харна уу.

Үнэлгээний үйл явц. Түгээмэл хэрэглэдэг гурван Үнэлгээний хандлагууд байдаг:

- **Зах зээлийн Хандлага (IVS 105 Үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, Бүлэг 20)**
- **Орлогын Хандлага (IVS 105 Үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, Бүлэг 40)**
- **Зардлын Хандлага (IVS 105 Үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, Бүлэг 60)**

Үнэлгээний хандлагуудын удирдамжийг IVS-аас харна уу.

Үнэлгээ тус бүр нь тодорхой нөхцөлд, цаг хугацаанд байна. Хамгийн сайн тохирох үнэлгээний хандлага нь хэд хэдэн хүчин зүйлээс хамаарах бөгөөд, үүнд хөгжлийн үе шат, хамгийн үр ашигтай хэрэглээ, үнэ цэнийн суурь, үнэлгээний өгөгдөл, өгөгдлийн боломжит нөхцөл, зах зээлд хэрэглэж байгаа хандлагууд, аргууд гэх мэт орно. Зарим Ашигт малтмалын хөрөнгөд, гурван үнэлгээний хандлагын хамгийн багадаа хоёр үнэлгээний хандлагын аргуудыг хэрэглэнэ. Үнэлгээний хандлагуудад олон үнэлгээний

аргууд байх бөгөөд, бусдаасаа аль илүү тохирохыг Үнэлгээнд хэрэглэнэ. Ашигласан Үнэлгээний хандлага, аргуудын үр дүнд дүн шинжилгээ хийж, Үнэ цэнийн талаар дүгнэнэ. Яагаад үнэлгээний хандлага, эсвэл арга аргачлал, нэг нь нөгөөгөө илүү байгаа шалтгаан, мөн гаднах хэсэгт (outliers) байгаа үнэ цэнийг яагаад хассан эсэхийг тайлбарлаж мэдээлнэ. Үнэ цэнийн дүгнэлтийг Үнэ цэнийн хэлбэлзлийн хүрээнд, ба/эсвэл нэг үнэ цэнээр мэдээлнэ.

Хэрвээ Үнэ цэнийн суурь нь Зах зээлийн үнэ цэнээр тодорхойлсон бол, Үнэлгээчин нь хэрэглэсэн үнэлгээ аргачлал, өгөгдлүүдийг зах зээлд оролцогчдын ойлголт, хүлээлтийг тооцон, холбогдох зах зээлээс авсыг баталгаажуулна.

Мөн IVS 104 Үнэ цэнийн суурь, Заалт 30 аас харна уу.

CIMVAL DRAFT: Мэргэшсэн үнэлгээчин нь ямар үнэлгээний хандлага, арга хэрэглэхийг шийдэхийн хариуцлагатай хандана. Сонгож хэрэглэсэн тодорхой хандлага, арга аргачлалууд, эсвэл хассан нөхцөлд Мэргэшсэн үнэлгээчин дүгнэн, тайлбарлах ёстой. Аргачлал тус бүрийн хязгаарлалтыг тайлбарлах ёстой.

Үнэлгээний тайланд түгээмэл хэрэглэдэг орлогын, зах зээлийн, зардлын үнэлгээний хандлагуудын талаар харгалзан үзэн, хэлэлцэх ёстой. Нэг болон түүнээс дээш үнэлгээний хандлагыг Ашигт малтмалын хөрөнгийг үнэлэхэд хэрэглэх ба, хэрвээ тохиромжтой бол тэдгээрийг хэрэглэнэ.

Хэрвээ Мэргэшсэн Үнэлгээчин нь онцгой нөхцөлд зөвхөн нэг хандлага хэрэглэх бол, Мэргэшсэн Үнэлгээчин нь энэ нөхцөлд яагаад бусад хандлагуудыг хэрэглээгүй шалтгааныг тайлбарлан, дүгнэх ёстой.

[CIMVAL Төсөл Удирдамжийг дагана.]

Сүүлийн өгүүлбэр “Үнэ цэнийн дүгнэлтэд Үнэ цэнийн хэлбэлзэл, ба/эсвэл үнэ цэнийн хэлбэлзлийн хүрээнд нэг үнэ цэнэ мэдээлнэ.” гэснээс бусдаар, 1-р догол өгүүлбэр нь IMVAL Загварын 4-р догол өгүүлбэртэй ижил,.

Хэрвээ Зах зээлийн үнэ цэнийг Үнэ цэнийн суурь гэсэн бол, Мэргэшсэн Үнэлгээчин нь үнэлгээний аргачлалд хэрэглэсэн өгөгдлүүдийг холбогдох зах зээлээс авсан гэдгээ батална.

[CIMVAL Төсөл Тусдаа Удирдамжийг дагана:]

Түгээмэл хэрэглэгддэг гурван Үнэлгээний хандлагууд байдаг, эдгээр нь Орлогын хандлага, Зах зээлийн хандлага, Зардлын хандлага зэрэг багтана.

Орлогын хандлага нь үр ашгийг урьдчилан тооцоолох зарчимд тулгуурлан, Ашигт малтмалын хөрөнгийн орлого, мөнгөн урсгалыг тооцох бүх аргыг багтаана

Зах зээлийн хандлага нь, “Худалдааны харьцуулсан Хандлага” гэдгээр мэдэх ба, орлуулалтын зарчим дээр тулгуурладаг. Үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгийг ижил төстэй ашигт малтмалын хөрөнгө, нээлттэй зах зээлд арилжлаалагдаж байгаа, ойролцоо шинжтэй, худалдааны үнэ цэнэтэй харьцуулан тооцдог. Арга аргачлалд харьцуулсан арилжаа, зах зээлийн капиталын анализ, опцион эсвэл, хамтын гэрээний нөхцлийн анализ зэрэг орно.

Зардлын хандлага нь үнэ цэнийн хувь нэмэр оруулалтын зарчим дээр тулгуурладаг. Үнэлсэн үнэ цэнийн аргыг түгээмэл хэрэглэдэг ба зах зээлийн нөхцөлд тохируулан, хайгуулын ажлын зардал, Ашигт малтмалын хөрөнгийн хэтийн төлөв бүхий хайгуулын ажилд хувь оруулсан байдалд дүн шинжилгээ хийх аргыг түгээмэл хэрэглэнэ.

SAMVAL: Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийг үнэлэхдээ доод тал нь хоёр үнэлгээний хандлагыг хэрэглэнэ. Хэрвээ нэгээс илүү хандлага хэрэглэх боломжгүй бол, Итгэмжлэгдсэн үнэлгээчин яагаад боломжгүй талаар тодорхой дүгнэн мэдээлнэ.

Гурван хандлага байна үүнд:

- 1) Орлогын хандлага. Орлогын хандлага “хэрэглээний үнэ цэнэ” зарчимд тулгуурлан, Ашигт малтмалын хөрөнгийн ашиглалтын жилийн хугацаанд ирээдүйн мөнгөн урсгалын одоогийн үнэ цэнийг тооцох шаардлагатай.
- 2) Зах зээлийн хандлага. Зах зээлийн хандлага нь худалдан авагч, худалдагчийн зарчимд тулгуурлан, мөнгөн дүн хараат бус бизнесийн хэлцэлээс Ашигт малтмалын хөрөнгийн худалдааны үнэ цэнийг тооцохыг шаардлагатай.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний логик хэрэглээ нь, нэгжийн үнэ цэнийг түүхийн эдийн үнэ, ашигт малтмалын агуулагын тооцоолсон бүтээгдэхүүнээс хялбар тооцоолохыг хүлээн зөвшөөрөхгүй эсвэл тохиромжгүй эсэхийг харгалзан үзнэ.

Зардлын хандлага. Зардлын хандлага нь Ашигт малтмалын хөрөнгийн түүхэн ба/эсвэл ирээдүйд зарцуулах мөнгөн дүнгээс хамаарна, үнэлгээний хандлага нь барилга, худалдан авалт хийхээс бусдаар, ашиг хүртэхээс үл хамааран түүнтэй тэнцэх төлбөрийг төлөхгүй байх гэсэн эдийн засгийн зарчимд суурилсан үнэлгээний арга юм. (IVSC-ын Тайлбар толь бичигт тодорхойлсноор).

Үнэлгээний үйл явц. Итгэмжлэгдсэн үнэлгээчний үйл явц эсвэл арга аргачлал нь Үнэлгээний зорилгод нийцсэн байна. Ил тод байхын тулд, үр дүн болон төлөвлөсөн зорилгод материаллаг нөлөө бүхий бүх зүйлд хөндлөнгийн хяналт хийх боломжтой байна. Хэрэглэсэн процесс, аргууд нь хэт нэг талыг баримтлахгүй байх эсвэл боломжтой мэдээллийг ашиглахыг эрэлхийлнэ.

SME: [Сүүлийн өгүүлбэрийг хассанаас бусад тохиолдолд, IMVAL Загвартай адил (IVS-аас лавлана уу)].

[SME Үнэлгээний үйл явцын Удирдамжийн 1-р догол нь IMVAL Загвартай ижил]

Түгээмэл хэрэглэдэг гурван хандлагын үнэлгээний аргуудын удирдамж нь IVS 105 -ын §30, §50, §70-д тус тус заасан. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний аргуудын хэрэглээний талаар судалгааны материалуудын мэдээллийг opetline.org -аас авч болно.

Үнэлгээний тус бүр тодорхой цаг хугацаанд нөхцөл байдалд байна. Хамгийн тохиромжтой Хандлага эсвэл Арга аргачлал хэд хэдэн хүчин зүйлүүд буюу хөгжлийн үе шат, хамгийн тохиромжтой хэрэглээ, үнэ цэнийн суурь, Үнэлгээний өгөгдөл, датаны боломжтой байдал, тухайн Ашигт малтмалын хөрөнгийн зах зээлд оролцогчдын хэрэглэсэн үнэ цэнийн үнэлгээний техник зэрэг байна.

Тодорхой Ашигт малтмалын хөрөнгийн хувьд, үнэлгээний арга нь багадаа л гурван хандлагаас хоёрыг хэрэглэсэн байна. Үнэлгээний хандлагуудын олон аргуудаас тохирох аргыг үнэлгээний ажилд хэрэглэнэ.

[SME Удирдамжийн 4,5-р доглын IMVAL -ын загвартай адил]

Энэ нөхцөлд, зах зээлд худалдагч, худалдан авагчийн хэрэгцээ шаардлагаар IVS нь худалдан авагчийн тодорхойлолд “ ... нь авахыг хүссэн эрмэлзэлтэй, гэхдээ худалдаж авахад албадаагүй. Худалдан авагч нь ямар ч үнээр хамаагүй авах эрмэлзлэл, шийдвэр

гаргахгүй байх. Худалдан авагч нь бодит байдлыг илэрхийлээгүй таамаглал эсвэл төсөөлөл бүхий зах зээлийн үндэслэлгүй мэдээллийн үндсэн дээр биш, харин зах зээлийн одоогийн хүлээлт, зах зээлийн бодит байдлыг үндэслэн худалдан авалт хийнэ. Худалдан авагч зах зээлийн бодит ханшаас хэт өндөр үнээр худалдан авалт хийхгүй.

Үүнтэй ижил утгаар, IVS-д худалдагчийг тодорхойлохдоо, худалдагч ямар ч үнээр зарахаар албадаагүй, хүсэл эрмэлзлэлгүй байх, одоогийн зах зээлийн харгалзан үзээгүй үндэслэлгүйгээр хэлэлцээр хийхгүй. Худалдаачин нь зохих нээлттэй зах зээлд хамгийн тохиромжтой үнээр, зах зээлийн нөхцөлөөр хөрөнгөө зарах хүсэл эрмэлзлэлтэй байх.

Жинхэнэ эзэмшигчийн бодит баримтат нөхцөл байдлыг харгалзахгүй бөгөөд, учир нь худалдагч нь таамаг бүхий эзэмшигч.” (IVS 104 Үнэ цэнийн суурь, §30.2(d), (e)).

VALMIN: Үнэлгээний хандлагын сонголт, хэрэглэх үнэлгээний аргууд нь Үнэлгээчний үүрэг хариуцлага ба, Үйлчлүүлэгч эсвэл бусад талууд нөлөөлөх ёсгүй. Үнэлгээний хандлагууд тус бүрт үнэлгээний аргууд нийтлэг оновчлол, суурь үндэслэлтэй боловч тооцооллын зарчим нь өөр байна.

Гурван түгээмэл хэрэглэгддэг Үнэлгээний хандлагууд байдаг:

- a) Зах зээлд суурилсан, энэ нь үндсэндээ орлуулах зарчим дээр тулгуурласан, Энэ үнэлгээний хандлага нь үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгийг нээлттэй зах зээлд ижилхэн цаг хугацаанд, ижил нөхцөлд байгаа ижилхэн Ашигт малтмалын хөрөнгийн худалдааны үнэ цэнийг харьцуулна. *Үнэлгээний аргачлал нь харьцуулалтын худалдааны гүйлгээ, хамтарсан гэрээний аргууд байна, үүгээр хязгаарлагдахгүй.*
- b) Орлогын арга нь мөнгөн урсгалд суурилсан. Энэ үнэлгээний хандлагад урьдчилсан төлөвлөсөн боломжит дүн шинжилгээг хийж байгаа Ашигт малтмалын хөрөнгийн мөнгөн урсгал эсвэл орлого ашиг байна. *Үнэлгээний арга нь хорогдуулсан мөнгөн урсгал, орлогын үржвэрийн аргууд байна, үүгээр хязгаарлагдахгүй.*
- c) Зардлын арга, үнэ цэнийн зардлын хувь хэмжээний ойлголт. Энэхүү үнэлгээний арга аргачлал нь дүн шинжилгээ хийж байгаа Ашигт малтмалын хөрөнгөд гарсан зардал. Үнэлгээний арга нь хуучин зардал эсвэл одоогийн орлуулах зардлууд.

Үнэлгээний хандлагууд, Үнэлгээний аргуудыг Олон улсын санхүүгийн тайлагнах стандартын дугаар 13 -аас авч үзэж болно.

[IMVAL Үнэлгээний үйл явцын удирдамжийн 3,4-р доглуудыг дараахи байдлаар орлуулсан:]

Өгөгдлүүдийн тодорхойгүй байдал, олон таамаглуудын хоорондын харилцан үйлчлэл зэргийг тусгахын тулд үнэ цэнийн хүрээг (Их/ойролцоо/доод) тодорхойлж олон нийтийн тайланд мэдээлнэ, гэхдээ Олон нийтийн тайлангийн үр дүнг ойлгомжтой байлгахын тулд уг хэлбэлзлийн хүрээ өргөн байх хэрэггүй. Олон нийтийн тайланд таамаглалыг хамгийн ихээр өөрчлөх нөлөөллийг харуулсан мэдрэмжийн шинжилгээг хийх ёстой. Бүх нөхцөлд, ойролцоо байх үр дүнг тодорхойлсон байна. Ямар нэгэн хийгээгүй зүйлийн шалтгааныг олон нийтийн тайланд мэдээлэх ёстой.

Үнэлгээчний хариуцлага

IMVAL: Үнэлгээчин нь үнэлгээ, ерөнхий үнэлгээний тайланг доор дурдсны дагуу хариуцана:

(a) Сонгосон үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд

(b) Шинжээч нь мэдээллийн дүгнэлтэд дэмжлэг үзүүлж байгаа эсэхийг баталгаажуулах, үнэлгээ нь зохих мэргэжлийн түвшинд, туршлагатай хүмүүсийн оролцоо, тусламж дэмжлэгийн талаар үнэлгээний тайланд мэдээлсэн эсэх, тусламжын талаар тайлбар хийхэд тэдний зөвшөөрлийг авч тайланд тусгасан эсэх.

(c) Хэрэглээний код, стандарт, бусад хэрэглэх зарчмууд, загварын шаардлагуудыг дагаж мөрдөх

(d) Үнэлгээнд хэрэглэсэн холбогдох мэдээлэл, тайлал, хэлэлцээр, дүгнэлт, урьдчилсан таамаглал, параметруудийн үндэслэлтэй байдлын үнэлгээ.

(e) Холбогдох улсын харьяаллын хүрээнд, Үнэлгээний тайлан, үнэлгээнд зориулсан хууль эрх зүйн шаардлагыг дагаж мөрдөж байгаа эсэх

(f) Үнэлгээний тайлан, үнэлгээг хариуцаж байгаа Үнэлгээчний мэдэгдэл.

CIMVAL DRAFT: (a) А Мэргэшсэн Үнэлгээчин нь ерөнхий Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, үнэлгээний тайлангийн боловсруулалт, бэлтгэлийг хариуцана. Мэргэшсэн үнэлгээчин нь нэг эсвэл түүнээс их Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчдийн ажлаас хамаарна (Заалт 2.1.1.-ыг харна уу)

(b) Мэргэшсэн үнэлгээчин нь Мэргэшсэн мэргэжилтэн биш тохиолдолд, үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгөтэй холбоотой бүх техникийн өгөгдлийг нэг буюу түүнээс их өөр Мэргэшсэн мэргэжилтнээр баталгаажуулах хэрэгтэй. Хэрвээ одоогийн техникийн тайлан нь аль хэдийн хийгдсэн тохиолдолд, Мэргэшсэн үнэлгээчин нь үнэлгээ хийхдээ туслалцаа дэмжлэг авч болох бөгөөд, энэ хамаарал нь хэр зэрэг байгааг үнэлгээний тайланд тодорхой мэдээлнэ.

(c) Мэргэшсэн үнэлгээчин нь үнэлгээнд оролцож байгаа Мэргэшсэн мэргэжилтэн, бусад шинжээчид эсвэл Мэргэшсэн үнэлгээчинтэй хамаарч байгаа хэн нэгнийг мэргэжлийн хувьд чадамжтай, туршлагатайг баталгаажуулах үүрэгтэй.

(d) Мэргэшсэн үнэлгээчин нь дараагийн хэсгийн нөхцөлд тодорхойлсоноос бусад тохиолдолд хараат бус байна. Үнэлгээний тайлан бүрт Мэргэшсэн үнэлгээчин, үйлчлүүлэгч, эсвэл бусад сонирхолын талууд, эдгээр нь мэргэшсэн үнэлгээний Хараат бус байдалтай холбоотой эсвэл дутагдалтай байдлыг эсвэл, шууд болон шууд бусаар төлөвлөж байгаа ажил хэргийн харилцааг өнгөрсөн, одоогийн байдлаар бүрэн хэмжээгээр тодорхой мэдэгдэнэ.

(e) Хэрвээ үнэлгээ нь тодорхой нөхцөлд, Мэргэшсэн үнэлгээчин нь хараат бус байж чадаагүй бол, Мэргэшсэн үнэлгээчин нь Үнэлгээний тайлангийн хураангуй, танилцуулгад ил тод мэдээлнэ. Үүнд (i) тодорхой нөхцөлд Мэргэшсэн Үнэлгээчний хараат бус байдал шаардагдаагүй талаар; (ii) Мэргэшсэн үнэлгээчин нь бие даасан байгаагүй нь (iii) Мэргэшсэн үнэлгээчний үйлчлүүлэгч байгууллага, лицензийн эзэмшигч, эсвэл Ашигт малтмалын хөрөнгийн сонирхлын талуудтай харилцаа холбоо байгаа, эсвэл тийм нөхцөлд.

(f) Мэргэшсэн Үнэлгээчин нь Мэргэшсэн үнэлгээчний тодорхойлолтод заасан бүх шинж чанруудад нийцсэнийг үнэлгээний тайланд баталгаажуулан, шаардлагатай бол үнэлгээний тайланг мэргэжлийн тамгаар баталгаажуулна. Мөн, Канадын Мэргэжлийн Ассоциацийн гишүүнчлэлгүй үнэлгээчид нь, Мэргэжлийн ассоциаци, холбогдох Өөрийгөө

удирдах Мэргэжлийн байгуулгын шаардлагад нийцэж байгааг гэрчилж, нотлох баримтыг харуулна.

(g) Мэргэшсэн үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, үнэлгээний тайлан, бусад шаардлагатай хууль эрх зүйн зохицуулалтын шаардлагын дагуу мэргэжлийн, материаллаг, шударга, объектив, үндэслэлтэй, хараат бус байх зарчмуудын стандартыг дагах үүрэгтэй.

(h) Мэргэшсэн үнэлгээчин нь үнэлгээний тайлан, үнэлгээтэй холбоотой бүх материал, ажлын файлуудыг Мэргэжлийн байгууллагууд, эсвэл хуулийн эрх зүйн хүрээнд шаардлагатай бол тайлагнасан өдрөөс хойш 5 -аас доошгүй жилийн хугацаанд эсвэл түүнээс удаан хугацаагаар хадгална.

SAMVAL: Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний материаллаг, ил тод, үндэслэлтэй, мэргэжлийн байх зарчмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь Ашигт малтмалын үнэлгээ, үнэлгээний хандлага, үнэлгээний арга, хэрэглэсэн техникийн өгөгдөл, мэдээлэл, техникийн тайлал, техникийн дүгнэлт, урьдчилсан таамаглал, параметруудийн тооцоолол, дүгнэлт, найдвартай байдал, өгөгдлүүдийн чанрыг хариуцна.

Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь ямар үнэлгээний хандлагууд, арга хэрэглэхээ хариуцна. Сонгож хэрэглэсэн болон, сонгоогүй хандлага, аргуудыг Итгэмжлэгдсэн үнэлгээчин дүгнэж тайлбарлана. Аргачлалын хэрэглээ, хязгаарлалтуудыг тайлбарлана.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээнд багийн ажиллагаа шаардлагатай байж болно. Тухайн баг ажлын үүргийн тодорхой хуваарьтай, Мэргэшсэн мэргэжилтэн эсвэл Техникийн Шинжээчид нь өөрсдийн ажлын хэмжээнд, ажлын үүрэг хариуцлагаа хүлээн зөвшөөрсөн байна. Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь ямар нөхцөлд хүмүүсийн ажлууд хоорондоо хамаарахыг хүн тус бүрээр тодорхойлон заана.

Үнэлгээний тайлангийн зохиогч нь тухайн ажил нь холбогдох бүх таамаглал, урьдчилсан нөхцөл, бэрхшээлүүдийг баримтжуулан, бүх материаллаг талуудыг хангалттай мэдэгдсэн, мэдээлэл бүхий уншигчид үндэслэлтэй, тэнцвэртэй дүгнэлт хийх боломжтой байх ба, олон нийтийн тайлан нь захиалагч байгууллага, компани, эсвэл хувь хүн нөлөөлөөгүй байх шаардлагыг хангана.

Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь Ашигт малтмалын үнэлгээг бүрэн хэмжээгээр, эсвэл бусдаар гүйцэтгүүлсэн хэсгүүдийн ерөнхийд нь хариуцаж, бусдаар хийлгэж хүлээн зөвшөөрсөн ажил, тайлангийн хэсгүүдийг гарын үсгээр баталгаажуулж ашиглах эрхтэй байна. Техникийн шинжээч нь мэргэшсэн мэргэжилтэнтэй дүйцэх, тодорхой практик туршлагатай байж, Итгэмжлэгдсэн үнэлгээчин мэргэжлийн чиглэлээр төрөлжүүлнэ.

Итгэмжлэгдсэн мэргэжилтэн, Итгэмжлэгдсэн, үнэлгээчний мэргэжлийн ур чадварын байдал, мэргэжлийн даалгавар, ердийн бүтэц үүрэг роль, хариуцлагууд Ашигт малтмалын үнэлгээний тайланд өөр өөр байна. Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь цогц тайлангийн шалгуурыг ойлгосон байх, үнэ цэнийг IVSC-ын Түгээмэл хэрэглэдэг үнэлгээний стандартад нийцүүлэн тайлбарлан, тайлагнахыг шаарддаг. Тиймээс, Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь дахин үнэлэх эсвэл үнэ цэнийн бууралт, хэлцэл хийх зорилгоор үнэлгээ хийх, эсвэл хайгуулын хөрөнгө, одоогийн холбогдох асуудлаар үнэлгээ хийхэд нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл шаардлагатай байж болно. Хэрвээ “компаний асуудал”-аар үнэлгээ хийхэд, нягтлан бодох бүртгэлийн үнэ цэнийн үнэлгээнд компанийн нэр хүнд, биет бус хөрөнгө зэргийг хэрэглэж болно. Эдгээр төрлийн ажлуудад, Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь голдуу том багийн бүрэлдэхүүн хэсэг байх ба, тиймээс IFRS болон IASB -ын тодорхойлолттой танилцах хэрэгтэй. Зарим нөхцөлд,

Зардлын болон Зах зээлийн хандлагийн аргыг хэрэглэсэнч, энэ үнэлгээ нь Мэргэшсэн мэргэжилтний тайланд шууд хамааралгүй байж болно.

Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ нь Хайгуулын ажлын үр дүн, Ашигт малтмалын баялаг, нөөцийн тайлангаас хамаарах ба, эдгээр нь SAMREC Кодын шалгуур үзүүлэлтийн дагуу, SAMREC кодоор, Мэргэшсэн мэргэжилтний гарын үсгээр баталгаажуулна. Зарим нөхцөлд, үнэлгээ нь CRIRSCO-д гишүүн орны кодуудаас хамаарах бөгөөд, Үйлчлүүлэгч байгууллага, харьяа бүс нутгийн хувьд тодорхой байна.

SME: ["Энэ загвар" гэдгийг "эдгээр стандартууд" гэж өөрчилсөнөөс бусад тохиолдолд IMVAL загвартай адил.]

VALMIN: Үнэлгээчний шалгуурууд. Мэргэжилтэн нь дараахи шалгуурыг хангана:

- (a) Мэргэшсэн ур чадвартай, ямар нэгэн Ашигт малтмалын хөрөнгөтэй холбогдох тайлан хийсэн, тухайн чиглэлдээ, ойрын хугацаанд доод тал нь 5 жил ажилласан туршлагатай;
- (b) Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний Техникийн үндэслэл хийсэн доод тал нь ойрын 5 жилийн туршлагатай, мөн Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ хийсэн тухайн чиглэлдээ доод тал нь ойрын 5 жилийн ажлын туршлагатай (доод тал нь нийтдээ 10 жилийн туршлагатай) байна.
- (c) Мэргэжлийн Ёс зүйн дүрмийг мөрдөх Мэргэжлийн байгууллагын гишүүн байх, Мэргэжлийн байгууллагын журмын дагуу VALMIN кодын зөрчлийн талаархи шалгалт хийхийг ойлгосон байх.
- (d) VALMIN Код, JORC код, Компаний тухай хуулийн шалгуурууд, ASIC, ASX, бусад хөрөнгийн биржүүдийн шалгуурууд, Олон нийтийн тайлан бэлтгэсэнтэй холбогдох шүүхийн шийдвэрийн талаар мэддэг байх.

Хэрвээ мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгийн тайлан бэлтгэх тохиолдолд, Эрэл хайгуулын шат, Нарийвчилсан хайгуулын шат, тухайн төслийн үе шатыг мэдээлэх бөгөөд тухайн шатны Техникийн үндэслэл тооцоо, Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тухайн чиглэлээр туршлагатай байх ёстой.

Хэрвээ нэг болон түүнээс дээш Ашигт малтмалын хөрөнгүүд нь Ашиглалтын өмнөх, илүү ахисан шатанд байвал, тухайн шатуудад аль нэг чиглэлээр Ашигт малтмалын үнэлгээ, Техникийн үндэслэлтэй холбогдох туршлагатай байх ёстой. Мэргэжилтний шаардлагын үндсэн шалгуур нь "холбогдох" гэсэн үг. Холбогдох туршлагыг тодорхойлох нь хэцүү боловч нийтлэг ойлголтыг ашиглах ёстой.

Мэргэжилтнээр ажиллахыг харгалзан үзэхийн тулд 'Холбогдох' гэдэг нь, мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгийн бүх төрлүүдэд 5 жилийн туршлагатай байх шаардагагүй гэсэн утгатай. Жишээ нь, Мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгийн Техникийн үндэслэлийн материалд хамрагдах ашигт малтмалын төрлөөр холбогдох 5 жилийн туршлагатай байхад, бусад ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний чиглэлээр 5 жилийн туршлагатай байх шаардлагагүй. Гэсэн хэдийч, тухайн ашигт малтмалын хөрөнгийн үндсэн үзүүлэлт болох геологи, уул уурхай, баяжуулалт, нийгэм, маркетинг, эрсдлийн параметруудийн ойлголттой байх шаардлагатай.

Ерөнхий удирдамжийн хувьд, тухайн мэргэжилтэн нь тухайн Ашигт малтмалын хөрөнгийн Техникийн үндэслэлийг хийхдээ, өөрийн мэргэжлийн чадвар, бусад мэргэжилтнүүдтэй ажиллах чадвараа харуулна. Хэрвээ ямар нэгэн эргэлзээ гарвал, мэргэжилтэн нь тохирох туршлагатай мэргэжилтнээс санлыг авах бөгөөд, эсвэл Мэргэжилтний үүргээс татгалзаж болно.

Техникийн үндэслэл, Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний ажил нь хамтын ажиллагааны хүч чармайлт байна. Тиймээс үүрэг хариуцлагаа тодорхой хуваарилан, мэргэжилтэн бүр үүрэг хариуцлага, хийх ажлаа хүлээн зөвшөөрөх ёстой.

Хэрвээ Техникийн үндэслэл, үнэлгээнд зөвхөн нэг хүнээр гарын үсэг зурж баталгаажуулвал, тухайн хүн VALMIN кодын дагуу баримт бичгийн хувьд бүхэлд нь хариуцлага хүлээнэ. Тухайн мэргэжилтэн нь бусад мэргэжилтнүүдийн ажлыг хүлээн зөвшөөрч Техникийн үндэслэл эсвэл үнэлгээ, бусад дагалдах баримтуудыг ерөнхийд хариуцаж хүлээн зөвшөөрөх нь чухал. Үнэт цаасны мэргэжилтэн нь үнэлгээнд оролцоходоо, эсвэл Ашигт малтмалын Үнэт цаастай (үндсэн Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний эсрэг) холбоотой зөвлөгөө өгөх эсвэл, худалдагчийн санал дүгнэлт өгөх тохиолдолд, санхүүгийн тусгай зөвшөөрлийн эзэмшигч байх ёстой. Австрали улсад, энэ нь AFSL-ыг Компаний тухай хуулийн 7-р заалтын дагуу шаардана.

Үнэлгээний тайлан

IMVAL: Үнэлгээний тайлан доод тал нь дараахи мэдээллийг агуулах ёстой (IVS 103 Тайлагнах).

- (a) Ашигт малтмалын хөрөнгийн тодорхойлолт.
- (b) Үнэлгээний зорилтот хэрэглээ, зорилтот хэрэглэгч, үнэлгээний хэрэглээний эсвэл түгээхэд ямар нэгэн хязгаарлалт байгаа эсэх.
- (c) Үнэлгээний зорилго.
- (d) Үнэ цэнийн суурь.
- (e) Тайлангийн өдөр, Үнэлгээний өдөр (Хүчинтэй өдөр), төөрөгдүүлэхгүйн үүднээс хамтад нь мэдээлнэ.
- (f) Боломжтой гэж үзвэл Үнэлгээний хугацаан дахь Хамгийн үр ашигтай хэрэглээг тодорхойлно.
- (g) Ажлын хамрах хүрээ.
- (h) Үнэлгээ хийж байгаа Ашигт малтмалын хөрөнгийн Геологийн тодорхойлолт, тухайн цаг хугацааны хайгуулын ажлын нарийвчилсан мэдээлэл, бүтээн байгуулалт, эсвэл бүтээгдэхүүн үйлдвэрлэл.
- (i) Таамаглал, эрсдэлүүд, болон хязгаарлалтууд
- (j) Ашигласан үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, үнэ цэнийн тооцооллын үр дүн тус бүрээр,
- (k) Эцсийн үнэ цэнийн тооцооллын нэгтгэл
- (l) Үнэ цэнийн талаар санал.
- (m) 3 жилийн хугацаан дахь үнэлгээний тухайн цаг үеийн ижил төрлийн ашигт малтмалын хөрөнгийн өмнөх үнэлгээний үнэ цэнийг мэдээлэх, хэрвээ боломжтой бол, Материалын ялгаатай байдлыг тайлбарлах. Үнэлгээчин 3 жилээс өмнөх тухайн цаг хугацааны үнэлгээг оруулж болно.

(n) Мэдээллийн эх үүсвэр болох өгөгдөл, мэдэгдэл, мэдээлэл нь баталгаажихгүйгээр найдвартай болохыг хүлээн зөвшөөрсөн, эсвэл үгүйг мэдээлэх.

(o) Ашигт малтмалын хөрөнгийн байгаа газартай биечлэн танилцсан, эсвэл үгүй эсэх мэдэгдэл.

(p) Үнэлгээ нь үндэсний холбогдох одоогийн мөрдөгдөж байгаа Ашигт малтмалын Хөрөнгийн Үнэлгээний код, стандартыг дагаж мөрдсөн эсэх, эсвэл дагаж мөрдөөгүй бол заавруудын тодорхойлолтын мэдээдэл.

(q) Тухайн шинжээч, үнэлгээчний туршлага, мэргэшил, тодорхойлолт, үнэлгээний тайлангийн хариуцсан чиглэлийн талаар

(r) Шинжээч, үнэлгээчний хараат болон хараат бус байдлын талаар мэдэгдэл

(s) Үнэлгээчний Ашигт малтмалын хөрөнгөтэй холбогдох хувийн ашиг сонирхол, эсвэл болзошгүй ашиг сонирхлын талаар, тухайн газарт очиж үзлэг хийсэн он сар өдрийн талаар мэдэгдэл.

CIMVAL DRAFT: Үнэлгээний тайлан доод тал нь дараахи мэдээллийг багтаах ёстой:

(a) Ажлын нөхцөл.

(b) Ажлын хамрах хүрээ.

(c) Үнэлгээний зорилго.

(d) Үнэлгээний зориултат хэрэглээ, зориултат хэрэглэгч, үнэлгээний хэрэглээний эсвэл түгээлтэд ямар нэгэн хязгаарлалт байгаа эсэх.

(e) Тайлангийн өдөр, Үнэлгээний өдөр (Хүчинтэй өдөр), төөрөгдүүлэхгүйн үүднээс хамтад нь мэдээлнэ.

(f) Үнэ цэнийн суурь.

(g) Ашигт малтмалын хөрөнгийн тодорхойлолт, эзэмшигчийн мэдээлэл.

(h) Үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгийн тодорхойлолт, байршил, хүрч очих боломж, түүх, геологи, эрдэсжилт, хайгуулын шат, бүтээн байгуулалт, үйлдвэрлэлийн талаар тухайн цаг хугацааны нарийвчилсан мэдээлэл

(i) Ашигласан үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд, гарсан үнэ цэнийн тооцоолол тус бүрээр,

(j) Нэгээс илүү хандлага эсвэл арга аргачлал ашиглан, гарсан үнэ цэнийн тооцоололын нэгтгэл

(k) Үнэлгээний эцсийн дүгнэлт.

(l) Үндсэн таамаглалууд, эрсдэлүүд, хязгаарлалтууд болон тайлбаруудын талаар тухайн нөхцөлд хэрэглэсэн таамаглалуудыг яагаад үндэслэлтэй, тохиромжтой гэж үзсэн талаар дүгнэх

(m) Үнэлгээнд тусгасан эсвэл хамааралтай техникийн мэдээлэл нь төслийн эдийн засгийн тооцоолол, тооцоололын тодорхойгүй байдлын түвшин, шинж чанарыг Мэргэшсэн үнэлгээчин зохих ёсоор тодруулан, мэдээлэх ёстой.

(n) 2 жилийн хугацаан дахь үнэлгээний тухайн цаг үеийн ижил төрлийн ашигт малтмалын хөрөнгийн өмнөх үнэлгээний үнэ цэнийг мэдээлэх, хэрвээ Үнэлгээчин нь Материалын ялгаатай байдлыг тайлбарлах. Үнэлгээчин 2 жилээс өмнөх тухайн цаг хугацааны үнэлгээг оруулж болно.

(o) Мэдээллийн эх үүсвэр, үүнд Үйлчлүүлэгч байгууллагын болон бусад эх үүсвэрээс авсан мэдээллүүд хамаарна.

(p) Ашигт малтмалын хөрөнгийн байгаа газарт биечлэн танилцсан эсэх, эсвэл үгүй талаар, хэн, хэзээ хийсэн талаар мэдэгдэл.

(q) Үнэлгээ нь бүхэлдээ стандартыг дагаж мөрдсөн талаар, эсвэл дагаж мөрдөөгүй талаар мэдээлнэ, мөн үнэлгээний тайланд хараат бус байдлыг дагаж мөрдсөн талаар, эсвэл хараат бус байдлыг дагаж мөрдөх шаардлагагүй байсан талаар мэдээлнэ.

(r) Үнэлгээ нь удирдамжтай хэр зэрэг нийцэж байгаа талаар мэдэгдэл. Хэрвээ Удирдамжтай нийцээгүй, дагаж мөрдөөгүй бол шалтгааныг тодруулж, тайлбарлах ёстой.

(s) Мэргэшсэн үнэлэгч, мэргэшсэн мэргэжилтнүүдийн тодорхойлолт, мэргэшил, туршлага, үнэлгээний тайлан бүрт хариуцах чиглэлийг мэдээлнэ. Бусад тайлан, мэдээлэлтэй хамааралтай болохыг тодорхойлно.

(t) Мэргэшсэн үнэлгээчид болон бусад мэргэшсэн мэргэжилтнүүдийн хараат бус байдал, бие даасан бус байдлын тухай мэдэгдэл.

(u) Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтний гэрчилгээ нь NI 43-101, 8.1-т заалтад нийцсэн мэдээлэлийг агуулна.

(v) Үнэлгээний тайлан нь тухайн үнэлгээний тайланд хариуцсан Мэргэшсэн Үнэлгээчин гарын үсэг зурах, эсвэл тухайн Мэргэшсэн үнэлгээчнийг ажлуулж эсвэл оролцуулж байгаа компани, түнш, хязгаарлагдмал түнш эсвэл бусад аж ахуйн нэгжүүд (**“Аж ахуйн нэгж” тус бүр**) болон хуулийн этгээдээр баталгаажуулагдана.

[Шалгах жагсаалт] 3.5.1-ийн заалтад Техникийн мэдээллийг лавлагаа байдлаар оруулахыг зөвшөөрдөг, 2.10, 2.11-ийн заалтад дурдсан сэдвийн хэлэлцүүлгийн дагуу мэдээллийн зорилгод зориулан, хураангуй байдлаар дараахи шалгах жагсаалтыг төлөвлөнө. Шалгах жагсаалт нь Дэлгэрэнгүй ойлгомжтой үнэлгээний тайланд тусгах боломжтой чиглэлүүдийг тодорхойлон Мэргэшсэн үнэлгээчинд дэмжлэг болоход зориулан хийгдэнэ.

Ойлгомжтой үнэлгээний тайлан гэдэг нь Мэргэшсэн үнэлгээчин нь шалгах хуудсанд дурдагдсан тухайн үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгөтэй холбогдох материаллаг зүйлүүдийг тодорхойлсныг хэлнэ. Хөрөнгийн төлөв байдлаас хамааран, нарийвчлалын түвшин өөрөөр байна.

Жишээ нь, 8, 9, 10-ын заалтын мэдээлэл нь Хайгуулын хөрөнгийг үнэлэхэд чухал ач холбогдолтой байхад, 11, 12, 13, 14-р зүйлүүд Үйлдвэрлэлийн шатны хөрөнгийн үнэ цэнийн мэдээллээс ихээхэн хамаарна.

1. Хураангуй

• Үйл ажиллагаа явуулах товч тайлбар, ажлын хүрээ, үнэлгээний өдөр, Ашигт малтмалын хөрөнгө, байршил, эзэмшигч, геологи, эрдэсжилт, хайгуулын, үйлдвэрлэлийн түүх, одоогийн нөхцөл байдал, хайгуулын боломж эсвэл үйлдвэрлэлийн

урьдчилсан таамаглал, Ашигт малтмалын нөөц, баялаг, үйлдвэрлэлийн байгууламж, байгаль орчны, зөвшөөрлийн мэдээлэл, үнэлгээний хандлага, арга аргачлалууд, үнэлгээ, дүгнэлт зэргийг тусгана.

2. Үйл ажиллагааны талаархи танилцуулга

- Үнэлгээний тайлангийн захиалагчийн тодорхойлолт, зориултат хэрэглэгчийн тодорхойлолт, Ашигт малтмалын хөрөнгийн эзэмшигчийн мэдээлэл, Үнэлгээний хөлс төлөлтийн баталгаажуулалт
- Үнэлгээний эрхийн танилцуулга, үйл ажиллагааны тайлбар
- Зориултат хэрэглээ, хэрэглэгч, хязгаарлалт, үнэлгээний зорилгын талаар хураангуй.
- Ашигт малтмалын хөрөнгийн товч тодорхойлолт, үнэлүүлэх хөрөнгийн сонирхол татах байдлын талаар дурдах, түүний үе шат, төрлийг тусгана.
- Үнэлгээ хийсэн огноо, Тайлангийн огноо бичнэ.
- Үнэлгээнд хамааралтай Мэргэшсэн Үнэлгээчин, бусад Мэргэшсэн Мэргэжилтний нэрс.
- Мэргэшсэн Үнэлгээчин, Мэргэшсэн Мэргэжилтний хараат бус байдал, эсвэл Хараат бус байдлыг дагаж мөрдөөгүй талаар хэлэлцэн тусгах.
- Тооцоолсон Үнэ цэнийн суурийн тодорхойлолт
- Тайланд ашигласан бусад тодорхойлолтууд.

3. Үнэлгээний хамрах хүрээ

- Гүйцэтгэсэн ажлын хамрах хүрээ
- Мэдээллийг дүгнэсэн, эсвэл хамааралтай эсэх, эх үүсвэрийн талаар тайлбарлах
- Холбогдох мэдээллийн найдвартай эсэх, бусад шинжээчдтэй хамаарлын түвшинг баталгаажуулалтыг тайлбарлах
- Өгөгдлийн баталгаажуулалт хэрхэн хийсэн тайлбар
- Тухайн газарт биечлэн очсон Мэргэшсэн Үнэлгээчин, Мэргэшсэн Мэргэжилтний нэрс, хэзээ хийгдсэн, юу шалгасан эсвэл яагаад тухайн газарт шалгалт хийгээгүйг тайлбарлах
- Хэрвээ өгөгдөл нууцлалтай бол, яагаад гэдгийг дурдах
- Ашигт малтмалын хөрөнгийн нэр, өгөгдөл, бусад холбогдох мэдээлэл, саналыг хүлээн зөвшөөрөхгүй байгааг мэдээлэх.

4. CIMVAL Стандартыг дагаж мөрдөх

- Үнэлгээ нь стандартын (2.10 (q)) заалтыг дагаж мөрдсөн мэдээлэл
- Хэрвээ Дэлгэрэнгүй үнэлгээ нь Удирдамжид нийцээгүй бол, яагаад үл нийцсэн, эсвэл зайлсхийсэн талаар мэдээлэн тайлбарлана (2.10 (r) заалтын дагуу).

5. Хөрөнгийн байршил, Нэвтрэх боломж, Дэд бүтэц

- Ашигт малтмалын хөрөнгийн нарийвчилсан байршил, тухайн талбайг оруулсан байршилын зургийг хийнэ.
- Том төвүүдэд хүрэх зайг тодорхойлох, тухайн хөрөнгө байрших газарт хэрхэн хүрэх зургийг хийнэ.
- Авто зам, төмөр зам, тээвэрлэлт, нисэх онгоцны буудал, цахилгаан, ус, дамжуулах хоолой, ажиллах хүч, хангамж, үйлчилгээ зэрэг дэд бүтцийн боломжийн талаар тайлбарлах.
- Цэргийн болон террорист үйл ажиллагаа, нийгмийн үймээн самуун, газар хөдлөлтийн эрсдэл гэх мэт бусад холбогдох орон нутгийн асуудлын тоймлон тусгах.
- Бүс нутгийн болон орон нутгийн хэмжээнд авто зам, төмөр зам, цахилгаан шугам, шугам хоолой, хаягдал хаях цэг зэрэг холбогдох бүх дэд бүтцийг харуулсан газрын зураг хийх. Үндэсний болон олон улсын системийг ашиглан газарзүйн координатыг мэдээлэх.

6. Хөрөнгийн эзэмшигч, төлөв байдал, зөвшөөрөл

- *Ашигт малтмалын хөрөнгийн нэр, хөрөнгийн өмчлөгчийн ашиг сонирхол, гадаргуун зөвшөөрөл, үүнд хөрөнгийн хүчин төгөлдөр байх хугацааны үүрэг хариуцлага, баталгаа, тусгай зөвшөөрөл, өмчлөгийн зөвшөөрөлийн дуусах хугацаа, өмчийн эрхтэй холбоотой бусад бэрхшээлүүдийг тайлбарлах.*
- *Опцион, хамтарсан аж ахуйн нэгж, хамтарсан гэрээ, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, буцааж авах эрх, төлбөр гэх мэт холбогдох хэлэлцээрийг тайлбарлах.*
- *Тухайн үнэлгээний хугацаанд Ашигт малтмалын өмчийн байдлыг тодорхойлох, хууль тогтоомжийн дагуу хийх ажлын шаардлага, газрын гадаргуугийн эрх, усны эрх, хөнгөлөлт, нутаг дэвсгэрийн газар эзэмших баталгаа, бусад хууль эрх зүйн асуудлууд, байгаль орчин, зөвшөөрөл олголтын асуудал, эдгээр нь хөрөнгийн хөгжлийн үйл явцад нөлөөлөх байдлыг тусгана.*

7. Хайгуулын болон үйлдвэрлэлийн түүх

- *Өмнөх хайгуулын ажлын он цагийн дараалал, эдгээрт ашигласан арга аргачлал, үр дүн, тухайн ажлыг гүйцэтгэх үеийн өмчлөгчийг мэдээллийг оруулна.*
- *Өмнөх хугацааны Ашигт малтмалын нөөц, баялгийн тооцооллыг хүснэгтээр харуулах, хэрвээ холбоотой гэж үзвэл, тооцооллын эх үүсвэртэй байна.*
- *Өмнөх үйлдвэрлэлийн жилийн тоо хэмжээ, агуулгыг харуулсан хүснэгт*
- *Боломжит ашигт малтмалын нөөц, бүтээгдэхүүнийн хоорондын нэгтгэлийг харуулах.*
- *Хэрвээ шаардлагатай гэж үзвэл, тухайн бүс нутгийн, зэргэлдээх хөрөнгийн ижил төстэй шинж чанрыг мэдээлэх.*

8. Геологи, Минералоги

- *Бүс нутгийн болон орон нутгийн геологи, эрдэсжилтийн талаар тайлбарлах.*
- *Ашигт малтмалын хөрөнгийн геологийг тайлбарлах.*
- *Хөрөнгийн талбайн хэмжээнд тархсан эрдэсжилт, холбогдох геологийн хамаарлын талаар тайлбарлах. Хамт эрдэсжсэн бүс газрын хэмжээ, геометр, шинж чанар, хам төрөл, тасралтгүй байдал, эрдэсжилтийн тархалтын талаар дэлгэрэнгүй мэдээлэх.*
- *Хайгуулын ажилд хэрэглэсэн ойлголт, модел, эрдэсжилтийн тархалт, эх үүсвэрийн талаар одоогийн ойлголтыг хураангуйлан мэдээлэх.*
- *Хэрэв шаардлагатай бол, дагалдах хөрөнгийн ижил төстэй мэдээллийг оруулах.*
- *Эрдэсжилт болон бусад холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг харуулсан бүс нутгийн болон тухайн хөрөнгийн геологийн зургийг хийх.*

9. Хайгуулын ажлын үр дүн, боломж

- *Ашигт малтмалын хөрөнгийн талбайд хийсэн сүүлийн үеийн хайгуулын ажлын талаар тайлбарлаж, үр дүн, ач холбогдлыг хэлэлцэх. Хайгуулын ажил, өгөгдлийн найдвартай байдлын талаар тусгах.*
- *Ашигт малтмалын хөрөнгийн эдийн засгийн хувьд ашигтай эрдэсжилтийн нээлт, хайгуул хийх боломжийн талаар санал өгөх.*
- *Ашигт малтмалын ач холбогдол бүхий ордыг тогтоосон тохиолдолд нэмэлт эрдэсжилтийг илрүүлэх боломжийг үнэлэх.*
- *Хөрш зэргэлдээх хөрөнгийн талаархи мэдээллийг зэргэлдээх хөрөнгө, үнэлж байгаа ашигт малтмалын хөрөнгийн мэдээллийг хоорондын ялгааг тодорхой зааж мэдээлнэ.*
- *Хууль, эрх зүйн маргаан, газрын зөвшөөрөл, зөвшөөрлийн асуудлууд, эсвэл хайгуулын ажлын бодит саад бэрхшээлүүд зэрэг цаашдын амжилтад нөлөөлөх бэрхшээлүүдийг тайлбарлана.*

10. Sampling and Assaying

- *Дээж авах арга, дээжийн байршил, тоо, төрөл, дээжийн шинж чанар, зай, эсвэл нягт, хамрах талбай зэргийг тайлбарлана.*

- Үр дүнгийн нарийвчлал, найдвартай байдал, Материаллаг байдлаар хэрхэннөлөөлөх аливаа өрөмдлөг, дээжлэлт, гарцын хүчин зүйлийг тайлбарлах.
- Дээж бэлтгэл, аюулгүй байдал, шинжилгээний журам, геохимийн шинжилгээний чанрын баталгаа, чанрын хяналтын журам, хяналтын шинжилгээний талаар тайлбарлах; тэдгээрийн зохистой байдлын талаар мэдээлэх.
- Шинжилгээний өгөгдлийг Мэргэшсэн мэргэжилтнээр баталгаажуулсан эсэх уг баталгаажуултад ямар нэгэн хязгаарлалт байгаа талаар тэмдэглэх.

11. Ашигт малтмалын баялаг, нөөц

- Одоогийн ашигт малтмалын баялаг, ашиглалтын нөөцийн тооцооллыг мэдээлэх, уг ажлыг Мэргэшсэн Мэргэжилтэн гүйцэтгэсэн болохыг баталгаажуулна. Хэрэв Ашигт малтмал баялаг ба/ эсвэл ашигт малтмалын нөөц нь шинэчлээгүй бол эдгээр нь яагаад үнэлгээний зорилгод хамаарахыг тайлбарлана.
- Ашигт малтмалын баялаг ба / эсвэл ашигт малтмалын нөөцийн хүчин төгөлдөр он сар өдрийг тэмдэглэж, нэмэлт дээжлэлт, үйлдвэрлэл, эсвэл ашигт малтмалын нөөц баялгийн хэмжээг өөрчилсөн бусад мэдээллийг тайлбарлах.
- Баялаг/ нөөцийн мэдээллийн бааз, түүнийг хэрхэн баталгаажуулсан талаар тайлбарлах.
- Геологийн тайлагнал ба эрдэсжилтийн үргэлжлэлийн талаар мэдээлэх.
- Тооцооллын арга, тэдгээрийг хэрхэн ашигласан талаар тайлбарлах.
- Захын агуулга, бохирдол, олборлолтын гарц гэх мэт техник, эдийн засгийн үзүүлэлтүүдийг хэлэлцэх.
- Ашигт малтмалын нөөцийн тооцоо ба дараагийн үйлдвэрлэлийн үр дүнгийн хоорондын нэгтгэлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх.
- Ашигт малтмал нөөц баялгийн ангилалын талаар мэдээлэх.
- Ашигт малтмалын нөөц, баялгийн тойм эсвэл блокууд, дээжлэлтийн өгөгдлийн тохируулга зэргийг харуулсан план зүсэлтүүдийг харуулах.

12. Металлург

- Эрдэсжилтийн минералогийг тайлбарлах.
- Металлургийн туршилтын дээжлэлтийн журмыг тайлбарлаж, дээжийн төлөөллийг мэдээлэх.
- Металлургийн туршилтын ажлын нарийвчилсан мэдээлэл, үүнд лаборатори, тухайн ажилд хэн хяналт тавьж, гүйцэтгэсэн, хэрэглэсэн арга аргачлал, үр дүнгийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх.
- Төлөвлөж буй, эсвэл одоогийн баяжуулалтын процесс, схемийг тайлбарлах.

13. Байгаль Орчин, Нийгмийн асуудлууд

- Үнэлж байгаа Ашигт малтмалын хөрөнгөтэй холбоотой байгаль орчин, тусгай зөвшөөрөл, нийгмийн, олон нийтийн хүчин зүйлсүүдийн талаархи мэдээлэх.
- Байгаль орчны стандартыг хангаж байгаа эсэх, ашигт малтмалын хөрөнгөд цаашидийн төлөвлөсөн ажилд, тусгай зөвшөөрөл хэрэгтэй эсэх, хайгуулын болон бүтээн байгуулалт, үйлдвэрлэлд тогтоох ямар нэгэн хязгаарлалт байгаа талаар тайлбарлах.
- Байгаль орчны судалгааны ажлын үр дүнг нэгтгэн, Ашигт малтмалын ордод олборлолтын үйл ажиллагаа явуулахад материаллаг нөлөөлөх үзүүлэх байгаль орчны мэдэгдэж байгаа асуудлыг мэдээлэх, эдгээрийг бууруулах төлөвлөгөө.
- Ашигт малтмалын хөрөнгийн төлөвлөгөө, шаардлагатай холбоотой нийгэм, олон нийтийн асуудлыг мэдээлэх, орон нутгийн иргэдтэй хийсэн гэрээ, хэлэлцээрийн байдлыг мэдээлэх.
- Бонд, уурхайн хаалтын өмнөх нөхөн төлбөр, нөхөн сэргээлт, хаалтын төлөвлөгөө, хаалтын дараах үүрэг хариуцлагын талаархи төлөвлөгөөг тайлбарлах.

14. Олборлолт, Баяжуулалтын үйл ажиллагаа

- Одоогийн болон ирээдүйд хийх ажлуудын тойм хураангуй.

- ТЭЗҮ-ийн шатанд байгаа хөрөнгө нь төлөвлөсөн болон дууссан урьдчилсан ТЭЗҮ, ТЭЗҮ, инженерчлэлийг нэгтгэн хураангуйлах, эдгээр судалгаануудын ач холбогдол, цаашдын ажлын төлөвлөгөөний талаар мэдээлэх. Үнэлгээнд нөлөөлж болзошгүй техникийн болон санхүүгийн асуудлуудыг тодорхойлж, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар мэдээлэх.
- Капитал, олборлолтын зардал, гэрээ, татвар, роялти талаар мэдээлэх.
- Мөнгөн урсгалын шинжилгээний үр дүн, эсвэл эдийн засгийн судалгааны дэлгэрэнгүй байдлаар мэдээлэх.

15. Үндсэн таамаглал, эрсдэл, хязгаарлалтууд

- Үнэлгээ хийхэд үндэслэсэн дүн шинжилгээ, санал, дүгнэлтэд нөлөөлөх бүхий л материаллаг таамаглал, хязгаарлалтын нөхцлийг тайлбарлан мэдээлэх.
- Ашигт малтмалын хөрөнгөтэй холбоотой материаллаг эрсдлүүд үүнд техникийн, үйл ажиллагаа, санхүү, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, зөвшөөрөл олголт, маркетинг, түүхий эдийн үнэ, улс төрийн эрсдлийн мэдээлэл.
- Тоон эрсдэлийн моделийн параметруудийг мэдээлэх.
- Удирдлагатай хамааралтай мэдээлэлийн талаар мэдээлэх.

16. Үнэлгээний хандлагууд, арга аргачлалууд

- Олон хандлагаас тохирох хэрэглээний талаар мэдээлэх, яагаад тухайн хандлагыг ашигласан, эсвэл ашиглаагүй талаар тайлбарлах.
- Үнэлгээний сонгосон аргаа тайлбарлах, тэдгээрийн хэрэглээний талаар дүгнэх.

17. Ойрын хугацааны үнэлгээ

- Ашигт малтмалын хөрөнгийн ойрын хугацааны үнэлгээг (сүүлийн хоёр жилийн хугацаанд) нэгтгэж, ашигласан аргуудыг товч тайлбарлаж, үнэлгээний үр дүнг мэдээлнэ. Өмнөх үнэлгээ нь яагаад энэ Үнэлгээтэй холбоотой эсвэл холбоогүй талаар тайлбарлах.

18. Үнэлгээ

- Үнэлгээ хийхдээ эдийн засгийн нөхцөл байдлын талаар дүгнэлт өгөх. Хайгуулын хөрөнгийн хувьд жижиг, том уул уурхайн компаниудын эзэмшилд байгаа үл хөдлөх хөрөнгийн эрэлт, хайгуулын ажлыг санхүүжүүлэх боломжийн талаархи тайлбарыг оруулна. Уул уурхай, үйлдвэрлэлийн шатны хөрөнгөд, уул уурхайн салбартай холбон өнөөгийн эдийн засаг, судалгаа хийж байгаа түүхий эдийн талаар мэдээлнэ. Түүхий эдийн үнийн төлөв байдал, санхүүжүүлэх боломж зэргийг дүгнэн мэдээлнэ.
- Тооцоололд хэрэглэсэн мөнгөн тэмдэгтүүдийн төрөл, ханшийн мэдээлэл.
- Үнэлгээний арга бүрт тохируулан ашигласан мэдээллийн сангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх.
- Орлогын хандлагыг ашиглах тохиолдолд санхүүжилтийн нөхцөл, татварын тооцоо, бараа бүтээгдэхүүний үнэд холбогдсон гэрээний нөхцөл, мөнгөний урсгалын тооцоонд зах зээлийн бусад хүчин зүйлүүд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлах.
- Орлогын хандлагад зохистой хоорогдуулалтын хувийн тооцооллыг тайлбарлах.
- Ашигласан мэдээллийн дүн шинжилгээ, дагаж мөрдсөн арга аргачлал, үнэ цэнийн талаархи шинжилгээ, санал, дүгнэлтийн шалтгаануудыг тодорхой тайлбарлах.

19. Үнэлгээний дүгнэлт

- Хэрэглэсэн арга аргачлал бүрээр үнэлгээний тооцоололын дүгнэлтийг мэдээлэх. Үнэлгээний тооцооллоос гарсан ямар нэгэн ач холбогдол бүхий ялгааг мэдээгдэх.
- Үнэ цэнийн хэлбэлзэх хэмжээг илэрхийлэн, Үнэлгээний дүгнэлт хийх. Discuss any reliance on or weighting of different Valuation estimates used to develop the range of values.
- Ганц утга авах шаардлагатай болсон үед, яагаад энэ утгыг сонгож хэрэглэсэн үндэслэлийг мэдээлэх.

20. Лавлагаа

Үнэлгээний тайланд дурдсан мэдээллийн бүх эх үүсвэрийн дэлгэрэнгүй жагсаалтыг оруулах.

21. Мэргэшлийн гэрчилгээ

• Үнэлгээний тайланд оролцсон Мэргэшсэн Үнэлгээчин, Мэргэшсэн Мэргэжилтэн бүр дараахь мэдээллийг агуулсан мэргэшлийн гэрчилгээтэй байна:

- Нэр, хаяг, ажил мэргэжил.

- Мэргэшилтэй холбогдох туршлага, боловсрол, Мэргэжлийн байгууллага бүрийн нэр, эсвэл Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтэн зэргийг олгодог Өөрийгөө удирдах Мэргэжлийн Холбоодын нэр,

- Тухайн үнэлгээний зорилгод нийцсэн Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтний тодорхойлолт.

- Ойрын хугацааны тухайн Ашигт малтмалын хөрөнгийн байрших газарт биечлэн очиж үзсэн огноо.

- Тухайн Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтэн бүрийн тайланд хариуцсан хэсэг чиглэлүүд.

- Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтэн нь Үнэлгээний тайланд төөрөгдүүлэхээр материалыг мэдээлэхгүй.

- Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтэн нь хараат бус байна.

- Мэргэшсэн үнэлгээчин, Мэргэшсэн мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгөтэй урьд өмнө нь ямар нэгэн хамаарал, оролцоотой байсан эсэх.

- Үнэлгээний тайланг Үнэлгээний Стандартад нийцүүлэн боловсруулах.

SAMVAL: Олон нийтийн тайлан болох Компанийн Ашигт малтмалын үнэлгээ нь Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үүрэг хариуцлага байна. Уг тайлан нь Итгэмжлэгдсэн Үнэлгээчин хийсэн Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээний тайлангийн баримт бичиг, дагалдах баримт бичгэнд тулгуурлан үнэн зөв мэдээлэх. Олон нийтийн тайланд Итгэмжлэгдсэн Үнэлгээчний нэр, мэргэшил, мэргэжлийн гишүүнчлэл, тухайн чиглэлийн туршлага, холбогдох Хуулийн байгууллага, Мэргэжлийн байгууллага, Хууль ёсны Мэргэжлийн Байгууллагад бүртгэгдсэн талаар мэдээлнэ. Хавсралт А-ийн 1-р хүснэгтэд заасан үнэлгээний шалгуур үзүүлэлт, тайлангийн дээд түвшний хяналтын жагсаалтыг Ашигт малтмалын үнэлгээний тайланд лавлагаа болгон хэрэглэнэ. Хяналтын жагсаалтыг "Хэрэв үгүй бол яагаад үгүй" гэсэн зарчмын дагуу авч үзэх ба, хамаарал, материаллаг байдал нь үргэлж олон нийтэд юуг мэдээлэхийг тодорхойлох зарчим юм. Олон нийтийн тайланд тодорхой үнэлгээний баримт бичгийг дурдах тохиолдолд, олон нийтийн тайланд оруулах баримт болох агуулга, сэдэв, маягтуудын талаар Итгэмжлэгдсэн үнэлгээчний зөвшөөрлийг бичгээр авна. *Итгэмжлэгдсэн үнэлгээчин нь эцсийн тайлангийн бүх уншигчид материаллаг, үнэн зөв баримт ашигласан, холбогдох өгөгдөл, мэдээллийн үнэн зөв байдлыг хангасан байх ёстой. Үнэлгээний эцсийн тайлан нь судалгааны чанар, тоон өгөгдлийн хооронд тэнцвэртэй байх, тухайн дүгнэлтийн зориулалт, зорилгыг тодорхой мэдээлнэ.*

Хүснэгт 1

[ХҮСНЭГТ 1, SAMVAL КОД ХАВСРАЛТ А; УДИРДАМЖ]

SME: [IVS 103-ийг устгаснаас бусад тохиолдолд, IMVAL загвартай ижил, текстийн ялгаа нь дараахи байдлаар байна:]

(k) Тооцсон үнэ цэнийн нэгтгэл.

(l) Үнэ цэнийн талаар санал.

(m) 3 жилийн хугацаан дахь үнэлгээний тухайн цаг үеийн ижил төрлийн ашигт малтмалын хөрөнгийн өмнөх үнэлгээний үнэ цэнийг мэдээлэх, хэрвээ боломжтой бол, Материалын ялгаатай байдлыг тайлбарлах. Үнэлгээчний саналыг харгалзан 3 жилээс өмнөх тухайн цаг хугацааны үнэлгээг оруулж болно.

(p) Үнэлгээ нь SME-ын Ашигт малтмалын үнэлгээний стандартыг дагаж мөрдсөн, эсвэл дагаж мөрдөөгүй бол энэ талаархи мэдээлэл.

(s) Тухайн үнэлгээчний мэргэжлийн ур чадварын гэрчилгээ, үүнд Үнэлгээчний Ашигт малтмалын хөрөнгөтэй холбогдох хувийн ашиг сонирхол, эсвэл болзошгүй ашиг сонирхлын талаар дурдсан, тухайн газарт очиж үзлэг хийсэн огноо, гарын үсэг зурж баталгаажсан талаар мэдээлэл.

VALMIN: Олон нийтийн тайлангийн зориулалт. Олон нийтийн тайлангийн зориулалт нь Ашигт малтмалын хөрөнгөтэй холбоотойгоор Үнэлгээчний саналыг товч, тодорхой, нарийвчлан авч үзсэний үндсэнд мэдээллийг цуглуулж, нэгтгэж, тайлбарлах явдал юм. Мэргэжилтэн нь олон нийтийн тайланд түүний тодорхой зорилгыг мэдээлэх, түүний техникийн нөхцөл, бусад зорилгоор ашиглахад ямар нэгэн хязгаарлалт байгааг мэдээлэх ёстой.

Олон нийтийн тайланд дараахи мэдээллийг агуулах бөгөөд, үүгээр хязгаарлагдахгүй:

- (a) Техникийн үнэлгээний тайлан,*
- (b) Үнэлгээний тайлан,*
- (e) Хараат бус шинжээчийн тайлан,*
- (e) Корпорацийн танилцуулга, ба*
- (d) (a), (b), (c) эсвэл (d) холбоотой хэвлэлийн мэдээлэл.*

Тодорхой, товч, үр дүнтэй. Олон нийтийн тайланг тодорхой, товч, үр дүнтэй байдлаар илэрхийлэх ёстой. Энэ нь мэдээллийн тайланг үгээр илэрхийлэх мэдээлэл (жишээ нь, хэлзүйн сонголт), танилцуулга (жишээ нь, харилцааны аргын сонголт) хоёуланд нь хамаарна. Үнэлгээчид холбогдох хууль эрхзүйн хүрээнд хэлзүйн үгс, танилцуулгын шаардлагыг мэдэх ёстой.

Австралид энэ талаархи удирдамжийг VALMIN кодод шууд хамруулан ASIC Зохицуулалтын RG 228 гарын авлага (энэ кодын огноотой) бүхий бичиг баримтаас авах боломжтой.

Техникийн нарийвчилсан мэдээлэл, өгөгдлийг Техникийн үнэлгээ эсвэл үнэлгээнд материаллаг гэж үзвэл Олон нийтийн тайланд оруулах ёстой. Техникийн үнэлгээ, үнэлгээний ойлголттой холбоотой өвөрмөц, шинэ техникийн үйл явц, үйл ажиллагааны тухай тайлбарыг оруулах.

Олон нийтийн тайлан нь боломжтой бодит өгөгдөлд үндэслэсэн үнэлгээнд суурилсан эцсийн дүгнэлт юм. Өөр өөр Үнэлгээчдээр хийсэн олон нийтийн тайлангууд өөр дүгнэлтийг гаргаж болно. Олон нийтийн тайлан нь холбогдох хүснэгтүүд, ойлгомжтой, газрын зураг, график танилцуулга, нэр томъёо, товчлол зэргийг агуулна.

Мэдээлэл. Олон нийтийн тайланд Үйлчлүүлэгч байгууллагын (бусад хөрөнгө оруулагчид, мэргэжлийн зөвлөхүүд) шаардагдах бүх мэдээллийг агуулсан, Олон нийтийн тайлангийн мэдээлэлд үндэслэн шийдвэр гаргана.

Олон нийтийн тайланд дараахь мэдээллийг агуулна:

- (i) Үнэлгээний дүгнэлт, үндсэн өгөгдөл, чухал таамаглалд тулгуурласан товч дүгнэлт байна,*
- (ii) Тайланд оролцсон зохиогчын хураангуй, тайлангийн үүрэг хариуцлагын чиглэлүүд, үүнд үнэлгээчний нэр, мэргэшил, холбогдох туршлагыг мэдээлэх;*
- (iii) Олон нийтийн тайлангийн хүчин төгөлдөр огноо,*
- (iv) Үнэлгээнд ашигласан валютын талаар мэдээгдэл,*
- (v) Холбогдох Ашигт малтмалын хөрөнгийн тодорхойлолт, тэдгээрийн байршил, үйлдвэр, тоног төхөөрөмж, дэд бүтэц, эзэмшигчийн тодорхойлолт,*
- (vi) Ашигт малтмалын хөрөнгийн Материаллаг байдлын түүхийн бүртгэл,*
- (vii) Тухайн Ашигт малтмалын хөрөнгийн ач холбогдол, үнэ цэнэ (хэрвээ боломжтой)*

бол), эрсдлийн талаар тодорхой мэдээлэл авахын тулд Мэргэшсэн мэргэжилтний дүгнэлт нь тэнцвэртэй, бодитой байна.

- (viii) Ашигласан мэдээллийн эх сурвалжийн мэдээлэл,
- (ix) Олон нийтийн тайланг хэрхэн боловсруулсан, ашигласан хандлагууд, аргуудын нарийвчилсан мэдээлэл, бусад үнэлгээчин үр дүнг ойлгох, дахин боловсруулахад хангалттай мэдээлэл байна,
- (x) Олон нийтийн тайланд холбоотой материаллаг бусад асуудлын дүгнэлт,
- (xi) *advise on reliance on third party personnel and/or disclaimers, and*
- (xii) гуравдагч этгээд, хариуцлагаас татгалзах хамаарлын талаархи зөвлөмж,
- (xiii) VALMIN кодтой зөрчилдөх, энэ нь материаллаг байдлаар нөлөөлөх тайлангийн хэсгийг дүгнэх.

Мэргэжилтэн нь холбогдох хууль эрх зүйн агуулга, шаардлагыг мэддэг байх ёстой. Австралид энэ талаархи удирдамжийг ASIC Зохицуулалтын RG 111 гарын авлага (энэ кодын огноотой) - аас авах боломжтой.

Эх сурвалж. Мэргэжилтэн нь Олон нийтийн тайланг боловсруулахад ашигласан бүх материаллаг мэдээлэл, өгөгдлийн эх сурвалжийг мэдээлэх ёстой.

Аливаа нууцлал, зохицуулалтын шаардлага, зөвшөөрөл, нийтлэгдсэн, нийтлээгүй тайлан, тэмдэглэлтэй холбоотой лавлагааг мэдээлэх ёстой. Мэргэжилтэн ашиглах боломжтой, тайлан, өгөгдөл, тэмдэглэлүүдийг материаллаг байхад яагаад ашиглаагүй шалтгааныг мэдээлэх хэрэгтэй. Үнэлгээчид бусад мэргэжилтний хийсэн тайлангийн хураангуй, жишээнийн маягтаас ашигласан ишлэлүүд, сэдвүүдийн анхдагч зохиогчийн хэлбэрээр байгааг баталгаажуулна. Мэргэжилтэн нь холбогдох хууль эрх зүйн зөвшөөрлийн шаардлагыг мэдэх ёстой.

Австралид бусад зохиогчид иш татах зөвшөөрлийг авах удирдамжийг ASIC Зохицуулалтын RG 55 гарын авлага (энэ кодын огноотой), ASIC Ангилалын тушаалын CO 07/428, 429 - аас авах боломжтой. Мэргэжилтэн нь мэдээлэл, өгөгдөлд шүүмжлэлтэй хандах ёстой.

Олон нийтийн тайлангийн дүгнэлт, өгөгдлүүд Үндэслэлтэй, Баримттай байх шаардлагыг хангах үүднээс Мэргэжилтний зохих хяналт, лавлагаа, дүн шинжилгээ, баталгаажуулалтын журмыг хэрэгжүүлэх ёстой. Техникийн үндэслэл, үнэлгээ хийсэн тухайн хугацаанаас хамаараад, цаг хугацааны шилжилтийн улмаас өгөгдөл, мэдээлэл хүчингүй болж болно. Энэхүү өөрчлөлтөд капитал, үйл ажиллагааны зардлын бүтэц, хайгуулын ажлын техник, геологийн тайлбар, уул уурхай, металлургийн технологийг харгалзан үзнэ.

Үүрэг хариуцлага. Мэргэжилтэн нь Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, техникийн үнэлгээнд ашигласан техникийн өгөгдөл, мэдээлэл, тайлбар, хэлэлцүүлэг, дүгнэлт, урьдчилсан тооцоо, параметрийн тооцооллыг хариуцах ёстой. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээг хийсэн Мэргэжилтэн нь үнэлгээний хандлага, арга аргачлалыг, олон нийтийн тайлангийн дүгнэлтийг хариуцах ёстой. Ашигт малтмалын хөрөнгийн үнэлгээ, техникийн үндэслэл гүйцэтгэх нь хамтын ажиллагаа байна.

Үүрэг хариуцлагын тодорхой хуваарьлалт, хүн бүр өөрсдийн оролцоонд тохирсон үүрэг хариуцлагатай байна. Мэргэжилтэн нь Олон нийтийн тайланд ямар ажлын нөхцөлөөр бусад гуравдагч этгээдээс хамааралтай, бусад этгээдүүдийн талаар тодорхой мэдэх мэдээлэл ёстой.

Зураг, газрын зураг, диаграм, хүснэгт. Ашигт малтмалын хөрөнгийг харуулсан газрын зураг, план зургууд нь Ашигт малтмалын хөрөнгө оршиж байгаа засаг захиргааны газрын батлагдсан стандарт координатын системийг ашиглах ёстой.

Олон нийтийн тайланд нийслэл, томоохон хотуудтай холбон Ашигт малтмалын хөрөнгийн газарзүйн байршлыг харуулсан гэрэл зураг, төлөвлөгөө, диаграм, график, газрын зургийг оруулна. Газрын зураг, төлөвлөгөө, бусад график мэдээлэл нь геологийн болон бусад онцлог шинж чанрыг хангалттай харуулсан байна.

Тухайлбал, газрын зураг дээр Ашигт малтмалын хөрөнгөд чухал нөлөө үзүүлэх ойролцоох төслүүдийг холбосон орон нутгийн тэмдэглэгээ, хил хязгаар, хэмжээ, байршлыг харуулна.

Олон нийтийн тайлангийн газрын зураг, график нь:

- (i) тохиромжтой масштаб, хүлээн зөвшөөрөгдсөн координатын системтэй байх;
- (ii) хойд зүгийг чиглэсэн сумын чиглүүлэг, масштаб, соронзон, зөв, хойд торлолыг харуулна;
- (iii) шаардлагатай бол гол дэд бүтцийг (үүнд; боомт, зам, цахилгаан, усан хангамж) харуулах;
- (iv) Хэвлэхэд хэмжээ нь жижгэрэхэд өгөгдөл нь алга болохгүйгээр уншигдахаар боловсруулна;
- (v) Хайгуулын үр дүнг харуулах тохиолдолд дээжлэлт, бусад хайгуулын ажлыг үнэлэхэд тохиромжтой масштабтай байх; ба
- (vi) Тухайн салбарын стандарт тэмдэгийг ашиглах.

Тухайн хөрөнгийн хэтийн төлөв бүхий хайгуулын ажил нь геофизик эсвэл геохимийн судалгааны ажлын үр дүнд үндэслэх бөгөөд, олон нийтийн тайланд тухайн судалгааны тайлбар, үр дүнг харуулан, график хэлбэрээр тайлбарлан харуулна.

Үнэлгээний судалгаа, үнэлгээний тайлангийн түвшин

IMVAL: Үнэлгээний судалгаа, үнэлгээний тайлангийн янз бүрийн түвшинд үндэсний код, стандартад заасны дагуу судална. Үнэлгээний судалгааны түвшин нь хамрах ажлын хүрээнд хийгдэх ажлын хэмжээнээс хамаарна. Үнэлгээний тайлангийн түвшин нь баримт бичгийн нарийвчлсан байдлаас хамаарна. Үнэлгээний судалгаа, тайлангийн түвшинг ажлын хүрээтэй уялдуулан тайланд тусгаж мэдээлнэ.

CIMVAL: Үнэлгээний тайлангийн төрлүүд. Үнэлгээний тайлан нь үнэлгээний дэлгэрэнгүй тайлан (а), үнэлгээний товч тайлан (б) хэлбэрээр байна. Үйлчлүүлэгч байгууллага, Мэргэшсэн үнэлгээчин нь Үнэлгээний дэлгэрэнгүй тайланг шаардлагагүй гэж үзвэл, үнэлгээний товч тайланг хангалттай болохыг хүлээн зөвшөөрсөн байна.

(а) **Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан.** "Үнэлгээний дэлгэрэнгүй тайлан" гэж 2.10-заалтын бүх шаардлагыг хангасан үнэлгээний тайланг хэлнэ.

(б) **Үнэлгээний товч тайлан.** "Үнэлгээний товч тайлан" гэж Үнэлгээний дэлгэрэнгүй тайланг үнэлгээний зориулалтад шаардлагагүй гэж үзвэл Үйлчлүүлэгч байгууллагын хүсэлтээр хийсэн үнэлгээний тайланг хэлнэ.

Үнэлгээний товч тайлан нь 2.10 заалтын шаардлагыг хангасан байна, (i) Холбогдох мэдэгдэл, одоогийн техникийн мэдээлэл нь 3.5.2 эсвэл NI 43-101 Маягт 1-т заасны дагуу нарийвчлалсан түвшинд биш бол, (ii) Үнэлгээ нь Үйлчлүүлэгч байгууллага, бусад талуудаас өгсөн техникийн мэдээллээс хамаарвал, эсвэл хязгаарлагдмал техникийн мэдээлэл, дүгнэлт байвал (iii) Үнэлгээний техникийн мэдээлэл нь Мэргэшсэн мэргэжилтнээр баталгаажихгүй бол (iv) Үнэлгээ, Үнэ цэнийн үр дүнгийн баталгааны түвшин нь Үнэлгээний дэлгэрэнгүй тайлангаас доогуур байх магадлалтай нөхцөлд. (v) Мэргэшсэн үнэлгээчин, эсвэл мэргэшсэн мэргэжилтэн талбайн үзлэг хийсэн эсэхээс.

SAMVAL: [дурдаагүй]

SME: [SME-ийн удирдамж IMVAL Загвартай ижил, нэмэлт өгүүлбэрийг дараах байдлаар бичнэ:] IVS 103 Тайлагнах, §20.1-д зааснаар "Үнэлгээний зорилго, үнэлж буй хөрөнгийн нарийн төвөгтэй байдал, хэрэглэгчдийн шаардлагууд нь үнэлгээний тайлангийн дэлгэрэнгүй байх эсэх түвшинг тодорхойлно. Ажлын хамрах хүрээг тогтоохдоо тайлангийн бүтцийн талаар бүх талууд харилцан тохиролцож зөвшөөрөх ёстой."

VALMIN: [дурдаагүй]